# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улаанбаатар хот

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

### *1.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт*:

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийслэл хэрэгжүүлэхээр тусгасан 209 арга хэмжээнээс нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт хамаарах доорх 3 ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг 4 жилээр нэгтгэн, хяналт, шинжилгээ үнэлгээгээр 100%-ийн биелэлттэй дүгнэгдэж, тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

*5.2.1.Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана.*

***6. Төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа эд хөрөнгийг илүүдэлтэй байгууллагаас дутагдалтай байгууллагад шилжүүлэх замаар хэрэгцээ шаардлагыг хангах зохицуулалт хийх, шаардлага хангахгүй хөрөнгийг акталж устгах, шинээр хөрөнгө худалдан авах асуудлыг оновчтой шийдвэрлэж, зардал хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх.***

Нийслэлийн өмчит байгууллагуудаас 2016-2020 онуудад ирүүлсэн хөрөнгийн хөдөлгөөний хүсэлтийг Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцах комиссын хурлаар хэлэлцүүлж давхардсан тоогоор 3,346 байгууллагын 52,006 нэр төрлийн нийт 173,139,844.107 төгрөгийн хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, тухайн байгууллагад тушаал болон албан бичгээр тайлан балансад тусгахыг даалган хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Үүнд:

- 288 байгууллагын 57,724,241.455 төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хасах,
- 364 байгууллагын 9,212,971.403 төгрөгийн эд хөрөнгийг шинээр худалдан авах,
- 300 байгууллагын 93,504,676.105 төгрөгийн эд хөрөнгийг шинээр бүртгэх,
- 128 байгууллагын 12,697,955.144 төгрөгийн эд хөрөнгийг илүүдэлтэй байгууллагаас дутагдалтай байгууллагын балансад шилжүүлэн шинээр хөрөнгө худалдан авах зардлыг хэмнэсэн.
- Ашиглалтын шаардлага хангахгүй, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдсон хөрөнгийг акталж, хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулж, 4 жилийн хугацаанд 751,997,500 төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн.

Нийслэлийн өмч хувьчлалын бодлогыг сайжруулах ажлын хүрээнд улсын төсөвт алдагдалтай, хувьчлах шаардлагатай 20 барилга байгууламж, 1 аж ахуй нэгжийг худалдан борлуулж, нийслэлийн төсөвт 34,858,213.700 төгрөгийг төвлөрүүлээд байна. 2016-2020 онд нээлттэй дуудлагын худалдаагаар:

- 2016 онд 198,277.500 төгрөг
- 2017 онд 5,038,529.000 төгрөг
- 2018 онд 8,702,000.000 төгрөг
- 2019 онд 314.974.000 төгрөг
- 2020 онд 20,751,309.200 төгрөг.

### *1.2 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:*

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн биелэлтийг нэгдүгээр улирлын байдлаар нэгтгэн 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 1/716 дугаар албан бичгээр, хагас жилийн биелэлтийг нэгтгэн, дүн шинжилгээ үнэлгээ хийлгэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст 06 дугаар сарын 04-ний өдрийн 1/1178 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн болно.

### ***1.6.1 Нийслэлийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр ашиг өгөөжийг нэмэгдүүлнэ.***

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан тус газраас хийж хэрэгжүүлэх 2 ажлын хүрээнд 4 арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган биелэлтийг ханган ажиллаж байна. Үүнд:

*1. Нийслэлийн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудыг зах зээлийн зарчимд шилжүүлнэ.*

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудыг хүнсний бүтээгдэхүүнээр ханган ажилладаг "Асгат", "Багачууд хүнс", "Өсвөр үе хүнс", "Хүнс хангамж" гэсэн 4 ОНӨААТҮГ-ын дүрмийг судлан үзэж, дүрмийн 4.2.3-т заасан "мал аж ахуй, хүнсний ногоо тариалалт, ахуйн бараа бичиг хэргийн хангалт, худалдаа эрхлэх, сургалт зохион байгуулах, мах ногоо ангилах, савлах жижиг үйлдвэр ажиллуулах, нийтийн хоолны тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ зэрэг туслах аж ахуй эрхэлж болно" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах чиглэл өгөн ажиллаж байна. Дээрх 4 үйлдвэрийн газрыг зах зээлийн зарчимд шилжүүлэх, дүрэмд заасан туслах аж ахуйн үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлэхэд бүтэц орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай болсныг үндэслэн Нийслэлийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/1093 дугаар захирамжаар бүтэц орон тоог шинэчлэн батлуулаад байна.

Нийслэлийн орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын нээлттэй зах зээлд өрсөлдөх замаар орлогын хэмжээг нэмэгдүүлэх, хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" ОНӨТҮГ-ын Австри улсын дэвшилтэт технологи, тоног төхөөрөмжийн нөөц бололцоонд тулгуурлан Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт "Асгат" ОНӨААТҮГ-т газар тариалан, фермийн аж ахуйг эрхлэхэд шаардлагатай газрын асуудлыг 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/497 дугаар захирамжаар Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой 16 үйлдвэрийн газрын 2020 оны эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинг хянан нийт орлогыг 257,3 тэрбум буюу 2019 оны гүйцэтгэлээс **25,9 тэрбум** төгрөгөөр нэмэгдүүлэн батлуулсан.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын захирлуудад 2020 оны зорилтын дагуу "Контракт"-аар хүлээсэн үүргээ биелүүлж орлогоо нэмэгдүүлэн, зардлыг хэмнэн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэн, менежментийг сайжруулан ажиллахыг үүрэг болгосон.

Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар ашигтай ажилласан 7 үйлдвэрийн газраас нийт 332,0 сая төгрөгийн ногдол ашгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн.

*2. Нийслэлийн өмчит байгууллага, аж ахуйн нэгжүүд, үйлдвэрийн газруудын эзэмшиж ашиглаж буй газрыг хамгаалах, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулна.*

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 193 дугаар тогтоолын дагуу төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах ажлын хүрээнд үнэлэгдэж, бүртгэлд тусаагүй үлдсэн нийслэлийн өмчит 58 хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн 93 нэгж талбарын судалгааг гаргаад байна. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолыг үндэслэн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, бүртгэлд тусгах бэлтгэл ажлыг ханган дээрх судалгаанд хамрагдсан 93 нэгж талбараас Баянгол дүүргийн нийслэлийн өмчит 3 байгууллагын 27 нэгж талбарын 6546 мкв талбай бүхий газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2020.04.28-ны өдрийн 08/495 тоот албан бичгээр хандсанаас, 3 асуудлыг шийдвэрлүүлсэн. Үүнд:

Нийслэлийн Засаг даргын 2020.05.04-ний өдрийн А/607 дугаар захирамжаар Баянгол дүүргийн 9 дүгээр хорооны 8 хүний халуун усны 1499 мкв газрыг 2 хувааж бүртгэлжүүлсэн.

- Баянгол дүүргийн 9 дүгээр хорооны цогцолбор барилга барих 12723 дугаар гэрчилгээтэй 522 мкв газар;
- Баянгол дүүргийн 9 дүгээр хорооны цогцолбор барилга барих 12724 дугаар гэрчилгээтэй 8 хүний халуун усны 977 мкв газар;
- Нийслэлийн Засаг даргын 2020.05.04-ны өдрийн А/608 дугаар захирамжаар Баянгол дүүргийн 10 дугаар хорооны цогцолбор барилгын 10895 дугаар гэрчилгээтэй 999 мкв бүхий газар.

Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Зөвлөлийн хурлын 2020.01.16-ны өдрийн 02 дугаар хурлаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 8 автомашины гараж, Тэрэлж хэсгийн эмнэлгийн газар эзэмших эрхийн гэрчилгээг Налайх дүүргийн Засаг даргын 2020 оны А/58, А/67 дугаар захирамжуудаар 15 жилээр гаргуулж, шийдвэрлүүлсэн. Нийслэлийн Боловсролын газарт нийт 80,624.6 м2 талбай бүхий 16 нэгж талбарын газар эзэмших, ашиглаж буй газрын гэрчилгээг гаргуулах, кадастрын зургийг баталгаажуулах, газрын маргааныг шийдвэрлүүлэх, шинээр ашиглалтад орсон боловсролын байгууллагад газар эзэмших эрхийг шилжүүлэх зэрэг ажлыг яаралтай зохион байгуулж ажиллах талаар 2020.06.04-ний өдрийн 2/1167 тоот албан бичгээр мэдэгдэл хүргүүлсэн болно.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн А/1307 дугаар албан бичгээр Сангийн сайдын 2020 оны 7/4446 дугаар албан бичигт газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээнд Сангийн сайдын 2018 оны "Аргачлал батлах тухай" 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалыг ашиглах чиглэл ирүүлсэн. Тус ажлын хүрээнд үнэлгээ хийгдээгүй орхисон газар эзэмших, ашиглах эрхийг дээрх

аргачлалын дагуу нөхөн үнэлж, дүнг 2020 оны санхүүгийн тайланд тусгуулах ажлыг хийж байна.

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Нийслэлийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд тус байгууллагаас дараах 5 саналыг боловсруулан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэн ажиллалаа.

1. Нийслэлийн хэмжээнд бие даасан бүртгэлийн нэгдсэн системийг бий болгох замаар төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, үр ашигтай болгох, мэдээлэл солилцох, нийслэлийн өмчит байгууллагууд цаг хугацаа, орон зайг үл харгалзан, интернэт сүлжээ ашиглан өмчийн өөрчлөлтийн талаарх мэдээлэлд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах
2. Нийслэлийн өмчийн хөрөнгийг эргэлтэд оруулж, өмч ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
3. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглал нэвтрүүлэх, өмчийн төлөөллийг хэрэгжүүлэн, ашигт ажиллагааны түвшинг нэмэгдүүлж үргүй зардлыг бууруулах
4. Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын аргачлалыг боловсруулан хэрэгжүүлнэ.
5. Нийслэлийн өмчийн илүүдэлтэй байр талбайг иргэн, аж ахуй нэгжид түрээслэн, байр талбайн ашиглалтыг сайжруулан, үр ашгийг дээшлүүлж, төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

### *2.1. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт*

Тайлант хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг-1, Засгийн газрын тогтоол-6, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол-55, Нийслэлийн Засаг даргын үндсэн үйл ажиллагаатай холбоотой захирамж -82, эрх шилжүүлсэн захирамж-225, захиалагчийн хяналт тавих тухай захирамж-14, Улсын Онцгой комисс, Нийслэлийн Онцгой комиссын хурлын тэмдэглэл, бусад баримт бичгийг бүртгэн, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна.

Дээд газрын шийдвэрийн хэрэгжилтийн байдал: /заалтаар, хувиар/

| | | Нийт | Ерөнхийлөгчийн зарлиг | Засгийн газрын тогтоол | НИТХ-ын тогтоол | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол | Нийслэлийн Засаг даргын захирамж | | | | Улсын Онцгой комиссын хурлын тэмдэглэл | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Үндсэн үйл ажиллагааны | Захиалагчийн хяналт тавих | Эрх шилжүүлэх тухай | Цаг үеийн шинж чанартай | | |
| Хяналтад авсан нийт шийдвэрлэлтийн тоо | | 417 | 1 | 6 | 2 | 55 | 80 | 13 | 225 | 18 | 16 | 2 |
| Бүрэнхэрэгжсэн | 100% | 189 | 1 | 4 | 1 | 55 | 74 | 11 | 8 | 18 | 16 | 2 |
| Хэрэгжих шатандаа | 70% | 3 | | 1 | | | 2 | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хэрэгжилт хангалтгүй | 30% | 1 | | | | | 1 | | | | | |
| Хугацаа болоогүй, үнэлэх боломжгүй | - | 224 | | 1 | 1 | | 3 | 2 | 217 | | | |
| Гүйцэтгэлийн хувь | | 99,1 | 100 | | - | 100 | 97 | 100 | - | 100 | 100 | 100 |

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Тогтоол, шийдвэр, захирамжийн хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын А/335 дугаар захирамжаар баталсан журмын дагуу холбогдох газарт хугацаанд нь тайлагнан ажиллалаа.

Нийслэлийн болон Байгууллагын шуурхай зөвлөгөөний үүрэг даалгаврын биелэлт

| | Хурлын тоо | Үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|---|---|
| Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн | 12 удаа | 70 | 95% |
| Байгууллагын шуурхай зөвлөгөөн | 8 удаа | 65 | 100% |

### 2.2. Зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын талаар:

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр захирамжаар батлагдсан "Нэг хот-Нэг стандартын жил болгон зарлах тухай" захирамжийн дагуу байгууллагын хэмжээнд хийж хэрэгжүүлэх 8 ажлын төлөвлөгөө, нийслэлийн нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан 5 ажлын биелэлтийг ханган ажиллаж улирал тутамд биелэлтийг нэгтгэн холбогдох газарт хугацаанд нь хүргүүлсэн байна. Зорилтот жилийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан танилцуулгыг 3 дугаар улирлын байдлаар гарган 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 1/1725 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Биелэлт 82% байна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

## БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

### *3.1.1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:*

Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ, байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдээс санал авч, Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Төлөвлөгөөнд 15 зорилтын хүрээнд 42 ажил арга хэмжээ тусгагдан, хэрэгжилтийг ханган ажилласан болно. Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн тайланг нэгтгэн, хяналт, шинжилгээ-үнэлгээ хийлгэхээр ажиллаж байна.

### *3.1.2. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 2020 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшний талаар:*

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт үйлдвэрийн газруудын үр ашгийг дээшлүүлэх, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд "Нийслэлийн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудыг зах зээлийн зарчимд шилжүүлнэ" гэж тусгасан заалтуудыг үндэслэн үйл ажиллагааны үр дүнг 2019 оны түвшингээс бууруулахгүй, үйл ажиллагааны хамрах хүрээг нэмэгдүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэхийг дэмжих, үндсэн үйл ажиллагаанаас гадна бусад төрлийн орлого олж төсвийн орлогыг нэмэгдүүлэх, зайлшгүй гарах зардлаас бусад зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулах боломжит арга замыг хэрэгжүүлэх зэрэг бодлогыг баримтлан үйлдвэрийн газруудын 2020 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтын төслийг хянан ажиллалаа.

Нийт 17 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хяналт тавин, чиглэл өгөн ажилласнаас 16 үйлдвэрийн газрын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг хянаж, тооцоотой Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/497 дугаар захирамжаар баталгаажуулсан.

Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын зорилтот түвшнийг харуулбал:

/мянган төг/

| № | Үзүүлэлт | 2019 оны | | 2020 оны | Өсөлт, бууралт /өмнөх оны гүйцэтгэлээс/ |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Хүлээгдэж буй гүйцэтгэл | Төлөвлөгөө | |
| 1 | Нийт орлого | 224, 584, 543.5 | 231, 451, 280.4 | **257, 383,665.5** | **25, 932, 385.10** |
| 2 | Нийт зардал | 266, 502, 177.6 | 266, 457, 029.4 | **305, 260,491.3** | **38, 803, 461.83** |
| 3 | Нийт ашиг, алдагдал | (41, 917, 634.0) | **(35, 005, 749.0)** | **(47, 876 825.7)** | **- 12, 871,076.73** |
| Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал | | 1.19 | 1.15 | **1.10** | **1.03** |

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой 16 үйлдвэрийн газраас 2020 оны зорилтын орлогыг 257,3 тэрбум төгрөгөөр, зардлыг 305,2 тэрбум төгрөгөөр, алдагдлыг 47,8 тэрбум төгрөгөөр буюу орлогын нэг төгрөгт ногдох зардлыг 1,19 төгрөг байхаар баталсан.

Өмнөх оны жилийн эцсийн гүйцэтгэлтэй харьцуулахад орлогын төлөвлөгөө 25,9 тэрбум төгрөгөөр, зардлын төлөвлөгөө 38,8 тэрбум төгрөгөөр, алдагдал 12,8 тэрбум төгрөгөөр, орлогын нэг төгрөгт ногдох зардлын хэмжээ 0,03 төгрөгөөр нэмэгдсэн.

2020 онд дэвшүүлж буй зорилтоор 47,8 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн нь дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Улс болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар үндсэн хөрөнгө ашиглалтад орж бий болсонтой холбоотой элэгдлийн зардлын хэмжээ 6,5 тэрбум төгрөгөөр өссөн;
- Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2018 оны 05 дугаар тогтоолоор 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс цалингийн доод хэмжээг 420,000 төгрөгөөр шинэчлэн тогтоосонтой холбоотой үндсэн болон нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлууд өссөн;
- Үнэ тарифын зохицуулалттай холбоотойгоор нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрууд нь орлогоороо зардлаа нөхөж чадахгүй, өндөр хэмжээний алдагдал хүлээсээр байгаа

ба нийт алдагдлын дийлэнх хувийг дараах байгууллагууд эзэлж байна. Үүнд: Ус сувгийн удирдах газар 28,6 тэрбум, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар 13,5 тэрбум, Зорчигч тээвэр гурав 3,4 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж байна. Мөн нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн элэгдлийн зардлын улмаас Геодези, усны барилга байгууламжийн газар нь 3,8 тэрбумын алдагдлыг хүлээж байна.

Мөн Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/952 дугаар захирамжаар "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ-ын 2020 оны эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинг 37,1 тэрбум төгрөг,зардлыг 41,8 тэрбум төгрөг, алдагдлыг 4,6 тэрбум төгрөгөөр, нийт хөрөнгө оруулалтыг 962 сая төгрөг байхаар тус тус баталж өгсөн.

Нийслэлийн өмчит нийт 17 аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2020 оны эдийн засгийн зорилтот түвшний хагас жилийн биелэлт, холбогдох судалгаа, мэдээллийг нэгтгэн ажиллаж байна.

Нийслэлийн өмчит байгууллагуудын эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшний 2020 оны хагас жилийн биелэлт

| № | Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын нэрс | 2020 оны зорилт | | | 2020 оны эхний хагас жилийн гүйцэтгэл | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Орлого | Зардал | Ашиг, алдагдал | Орлого | Зардал | Ашиг, алдагдал |
| 1 | Орон сууц нийтийн аж ахуй удирдах газар | 96,528,332.4 | 109,979,681.4 | (13,451,349.0) | 55,955,927.9 | 60,540,434.5 | -4,584,506.6 |
| 2 | Ус сувгийн удирдах газар | 68,159,646.5 | 96,746,185.2 | (28,586,538.7) | 31,520,000.2 | 41,522,171.0 | -10,002,170.8 |
| 3 | Зорчигч тээвэр гурав | 12,689,563.3 | 16,069,256.80 | (3,379,693.5) | 5,322,157.1 | 6,707,372.5 | -1,385,215.4 |
| 4 | Зорчигч тээврийн нэгтгэл | 37,193,043.0 | 41,882,891.00 | (4,689,848.0) | 16,239,083.2 | 18,623,236.3 | -2,384,153.1 |
| 5 | Хот тохижилтын газар | 15,576,715.3 | 15,249,563.8 | 327,151.5 | 8,943,456.8 | 10,936,841.3 | -1,993,384.5 |
| 6 | Өсвөр үе хүнс | 7,654,366.3 | 7,505,253.4 | 149,112.9 | 314,298.2 | 503,629.2 | -189,331.0 |
| 7 | Хүнс хангамж төв | 7,446,065.0 | 7,398,811.5 | 47,253.5 | 283,806.7 | 465,075.1 | -181,268.4 |
| 8 | Багануур хүнс | 5,172,096.9 | 5,068,455.2 | 103,641.7 | 290,910.2 | 419,954.8 | -129,044.6 |
| 9 | Асгат | 4,835,769.6 | 4,756,654.93 | 79,114.7 | 126,364.7 | 325,734.7 | -199,369.9 |
| 10 | Геодези, усны барилга байгууламжийн газар | 5,805,391.6 | 9,631,320.2 | (3,825,928.6) | 1,718,203.5 | 3,693,270.0 | -1,975,066.5 |
| 11 | Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар | 4,021,022.7 | 4,021,022.7 | - | 2,010,398.9 | 2,040,869.4 | -30,470.5 |
| 12 | Хөрөнгө оруулалтын газар | 5,128,500.0 | 4,828,671.0 | 299,829.0 | 1,875,759.0 | 1,563,175.0 | 312,584.0 |
| 13 | Хот төлөвлөлт, судалгааны институт | 2,504,896.6 | 2,477,535.0 | 27,361.6 | 929,761.1 | 893,945.5 | 35,815.6 |
| 14 | Гэрлэх ёслолын ордон | 1,248,557.0 | 1,154,005.0 | 94,552.0 | 30,068.3 | 304,214.8 | -274,146.5 |
| 15 | УБ зам засвар, арчлалтын газар | 20,477,425.5 | 20,213,758.4 | 263,667.1 | 3,181,997.8 | 4,236,327.9 | -1,054,330.1 |
| 16 | Үртсэн шахмал түлшний үйлдвэр | 66,620.7 | 91,620.7 | (25,000.0) | 38,864.0 | 43,823.3 | -4,959.3 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | Багахангайн Мах боловсруулах үйлдвэр | 68,696.1 | 68,696.1 | - | 39,187.6 | 38,373.6 | 813.98 |
| | **Нийт дүн** | **294,576,708.5** | **347,143,382.3** | **(52,566,673.7)** | **128,820,245.2** | **152,858,448.9** | **-24,038,203.7** |

Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрууд нь 2020 онд 294,5 тэрбум төгрөгийн орлого олж, 347,1 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 52,5 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж ажиллахаар батлагдсан бол хагас жилийн байдлаар 128,8 тэрбум төгрөгийн орлого олж, 152,8 тэрбум төгрөгийн зардал гарган 24,0 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

### *3.1.3. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууудын захиралтай байгуулсан контрактын 2019 оны биелэлт дүгнэсэн талаар:*

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны "Журам гэрээний үлгэрчилсэн загварыг шинэчилэн батлах тухай" 54 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай Контракт байгуулах, дүгнэх журам"-ын дагуу орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан Контрактын биелэлтийг хэлэлцэн дүгнэлээ.

Нийт 17 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газраас 2019 онд 15 үйлдвэрийн газар үйл ажиллагаагаа хэвийн явуулж, 2 үйлдвэрийн газар нь менежментийн хувьчлалын жагсаалтад орсноор үйл ажиллагаа явуулаагүй тул дүгнэгдэх боломжгүй байна.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн A/900 дүгээр захирамжаар Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын захиралтай байгуулсан 2019 оны Контрактыг дүгнэсэн дүнг баталгаажуулсан.
Контракт дүгнэсэн дүнг харуулбал:

| *Д/д* | *Үзүүлэлт* | *Контракт дүгнэсэн дүн* |
|---|---|---|
| ***1*** | *Бүрэн хангалттай* | *5* |
| ***2*** | *Хангалттай* | *4* |
| ***3*** | *Ажил сайжруулах шаардлагатай* | *5* |
| ***4*** | *Хангалтгүй* | *1* |
| ***5*** | *Үнэлгээ өгөөгүй* | *2* |
| | *Нийт* | *17* |

Контракт дүгнэсэн дүнгээр зорилтот түвшинг давуулан биелүүлсэн 4 үйлдвэрийн газрын захирлыг зорилтот дүнгээс давсан ашгийн 20 хувь, 2 үйлдвэрийн газрын захирлыг 3 сарын үндсэн цалингаар тус тус урамшуулав.

Дээрхи захирамжаар Нийслэлийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл "Контракт"-аар хүлээсэн үүргээ биелүүлж, орлого үр дүнг нэмэгдүүлэн, авлага, өр төлбөрийг бууруулан, дэлхий дахинд коронавирусын халдвар тархаж, онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбоотой тэвчиж болох зардлыг танаж үйл ажиллагааны менежментийг сайжруулан ажиллахыг нийт орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын захирлуудад үүрэг болгосон.

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын орлого, зардал, ашиг алдагдал:

/сая төгрөг/

| № | Үзүүлэлт | 2018 оны гүйцэтгэл | 2019 оны зорилт | 2019 оны гүйцэтгэл | 2019 оны биелэлт хувиар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нийт орлого | 243,807.50 | 263,403.70 | 268,895.70 | 102.1 |
| 2 | Нийт зардал | 275,026.90 | 309,323.20 | 304,367.80 | 98.4 |
| 3 | Нийт ашиг, алдагдал | -31,219.40 | -45,919.50 | -35,472.10 | 77.2 |
| 4 | Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал | 1.13 | 1.17 | 1.13 | 96.4 |

2019 онд үйл ажиллагаа явуулсан 17 орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд нь нийт 268,9 тэрбум төгрөгийн орлого олж,  304,4 тэрбум төгрөгийн зардал гарган 35,5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Дээрх дүнгээс харахад орлогын төлөвлөгөө 102,1 хувийн биелэлттэй, зардал 2,6 хувиар хэмнэгдэн, алдагдлын хэмжээ зорилтот түвшнээс 10,4 тэрбум төгрөгөөр буюу 22,8 хувиар буурсан байна. */Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын нийт орлого зардал, ашиг алдагдлын судалгааг хавсралтаар харуулав./*

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой 8 үйлдвэрийн газар нийт 370.6 сая төгрөгийн цэвэр ашигтай, 9 үйлдвэрийн газар нийт 35,8 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

Хамгийн өндөр ашигтай ажилласан газруудыг дурдвал: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар  98,2 сая, Өсвөр үе хүнс 92,6 сая, Гэрлэх ёслолын ордон 72,6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

Алдагдалтай ажилласан үйлдвэрийн газруудаас Ус сувгийн удирдах газар 16,8 тэрбум, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар 11,2 тэрбум, Зорчигч тээвэр гурав 1,5 тэрбум, Геодези усны барилга байгууламжийн газар 3,8 тэрбум, Хот тохижилтын газар 1,2 тэрбум, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар 0,6 тэрбум, Зорчигч тээврийн нэгтгэл 0,4 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Дээрх 5 байгууллага нийт алдагдлын 99,2 хувийг эзэлж байна.

### *3.1.4. Нийслэлийн Өмчит үйлдвэрийн газар болон оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Удирдах зөвлөлд нийслэлийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх:*

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Удирдах Зөвлөл, Төлөөлөн Удирдах Зөвлөлд өөрчлөлт орсонтой холбоотой Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 213 дугаар тогтоолыг хүргүүлсэн.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 130 дугаар тогтоолоор удирдах зөвлөл болон төлөөлөн удирдах дарга, гишүүнээс нийт 12 үйлдвэрийн газар, 8 нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл болон удирдах зөвлөлийн дарга, гишүүдээр ажиллаж байсан нэр бүхий нийт 34 төлөөлөгч, 2 хараат бус гишүүнийг тус тус чөлөөлж холбогдох газруудад тогтоолыг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын Удирдах зөвлөл, орон нутгийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулах ажлыг зохион байгуулан дараах газруудын хуралд нийслэлийн өмчийн бодлого, менежментийн талаарх саналыг тусгуулж ажиллалаа. Үүнд;

1. Геодези усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийн хуралд 1 удаа оролцож санал өгсөн.
2. "Хишиг-Уул" ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилуулж, хэлэлцэх асуудлыг судлан холбогдох саналыг боловсруулж, Нийслэлийн Засаг даргаар удирдамжийг батлуулсан.
3. "Гэрлэх ёслолын ордон" ОНӨААТҮГ-ын хурлыг шинэ бүрэлдэхүүнээр 2 удаа хуралдуулж, Удирдах зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг сонгон 2019 оны үйл ажиллагааг дүгнэж 2020 оны зорилтот түвшингийн төслийг дэмжиж баталгаажуулах,байгууллагын бүтцийг орон тооны дээд хязгаарт багтаан өөрчлөлт оруулах асуудлыг тус тус шийдвэрлэсэн.
4. "Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2 удаагийн хурлын холбогдох бичиг баримт гаргасан тогтоолыг авсан болно.
5. "Төв цэнгэлдэх хүрээлэн" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх асуудалд өгөх санал, дүрмийн төсөлд өгөх саналыг боловсруулж, ТУЗ-ын хуралд итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилуулж 1 удаагийн хуралд оролцсон.
6. Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын Удирдах зөвлөлийн 2 удаагийн хуралд оролцож санал, дүгнэлт өгсөн.
7. Зорчигч тээвэр-3 ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөл 2 удаа хуралдсан.
8. Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийн хурал 2 удаа хуралдсан.

### *3.2. Хөрөнгийн хөдөлгөөний талаар хийж хэрэгжүүлсэн ажил:*

#### *3.2.1. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн ажлын талаар*

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө, төсөл хөтөлбөр, гадаадын зээл, буцалтгүй тусламж, гадаад дотоодын хандив бэлэглэлээр нийслэлийн өмчид шинээр бий болсон **160,864.7 сая** төгрөгийн эд хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэж, эзэмшигч байгууллагын данс бүртгэлд тусгуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Барилга байгууламж 119 — **102,920.3 сая** төгрөг
2. Тээврийн хэрэгсэл 174 — **16,877.1 сая** төгрөг
3. ЭБХХХК-ын хурлаар бүртгэсэн эд хөрөнгө: – **2,352.2 сая** төгрөг
4. Шинээр бий болсон эд хөрөнгө: – **38,715.1** сая төгрөг

*Нэг. Барилга байгууламж – 119 нэрийн* **102,920.3** ***сая*** *төгрөг*

- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020.02.12-ны өдрийн 19 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2020.03.09-ний өдрийн А/320 дугаар захирамжаар улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр баригдаж ашиглалтад орсон нийт 24,945,204,348 төгрөгийн 14 барилга байгууламж /Баянзүрх дүүргийн 115-р цэцэрлэгийн өргөтгөл, 251-р цэцэрлэг, 127-р сургууль, Сүхбаатар дүүргийн Аврах гал унтраах 74-р ангийн барилга, 6 автомашины гараж-контор, 149-р цэцэрлэгийн өргөтгөл, Баянгол дүүргийн Ахмад хөгжлийн төв, Засаг даргын Тамгын газрын өргөтгөл, Сонгинохайрхан дүүргийн 228, 253-р цэцэрлэгийн барилга, Чингэлтэй дүүргийн Хайрхан хөгжлийн төв, 258-р цэцэрлэг, 19-р цэцэрлэгийн өргөтгөл, Хан-Уул дүүргийн 32-р сургууль/,
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020.03.31-ний өдрийн 39 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын А/518 дугаар захирамжаар Бүгд

найрамдах Солонгос улсын хөрөнгө оруулалттай "Хамтын дэлхий" төрийн бус байгууллагын буцалтгүй тусламжаар Хан-Уул дүүргийн 13 дугаар хороонд баригдаж ашиглалтад орсон нийт 301,6 сая төгрөгийн өртөгтэй, 50 хүүхдийн хүчин чадал бүхий цэцэрлэгийн барилга,

- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020.03.31-ний өдрийн 40 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2020.04.16-ны өдрийн А/519 дүгээр захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Сонгинохайрхан дүүргийн 1, 2-р хороо, Хан-Уул дүүргийн 10-р хорооны нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон нийт 2,234,067,507 төгрөгийн өртөг бүхий түлшний агуулахын 3 барилга байгууламжийг,
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020.04.09-ний өдрийн 51 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2020.04.23-ны өдрийн А/566 дугаар захирамжаар Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон 1,512,546,325 төгрөгийн өртөг бүхий 100 дугаар цэцэрлэгийн 150 ортой өргөтгөлийн барилга байгууламжийг,
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020.04.09-ний өдрийн 55 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2020.04.23-ны өдрийн А/565 дугаар захирамжаар "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл 1"-ийн хүрээнд АХБ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Сонгинохайрхан дүүргийн 8-р хорооны нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон 4 797,381,612.31 төгрөгийн өртөг бүхий Бизнес инкубатор сургалт үйлдвэрлэлийн төвийн барилга байгууламжийг,
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020.04.30-ны өдрийн 61 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2020.05.14-ний өдрийн А/651 дүгээр захирамжаар Чингэлтэй дүүргийн 7-р хорооны нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон 1,754,789,848 төгрөгийн өртөг бүхий Өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн барилга байгууламжийг,
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020.04.30-ны өдрийн 64 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2020.05.14-ний өдрийн А/650 дугаар захирамжаар Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон 1,820,932,171 төгрөгийн өртөг бүхий Гал унтраах, аврах 80-р ангийн барилга байгууламжийг,
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020.05.11-ний өдрийн 71 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2020.05.27-ны өдрийн А/737 дугаар захирамжаар Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон нийт 5,339,737,301 төгрөгийн өртөг бүхий 12 барилга байгууламжийг /88-р сургуулийн спорт заал, гүний худаг-СХД-д 6, БЗД-3, 142-р сургуулийн барилга, БЗД-ийн ЭМТ-ийн амбулатори №1-ийн өргөтгөл,
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 39 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын А/518 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн 13 дугаар хороонд баригдаж ашиглалтад орсон нийт 301,6 сая төгрөгийн өртөг бүхий 50 хүүхдийн хүчин чадал бүхий цэцэрлэгийн барилга,
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020.05.19-ний өдрийн 86 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2020.06.16-ны өдрийн А/828 дугаар захирамжаар Баянгол дүүрэг, Баянзүрх дүүрэг, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр баригдаж ашиглалтад орсон нийт 2,346,082,466 төгрөгийн өртөг бүхий Ус дулаан дамжуулах төвийн барилга байгууламж, шугам

сүлжээг /Мамба дацан хийд орчим, Дэнжийн 1000, 14-р хорооллын "Е" хэсэгчилсэн талбай, Гандантэгчилэн хийд орчим/

- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020.05.19-ний өдрийн 87 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2020.06.16-ны өдрийн А/829 дүгээр захирамжаар улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт болон Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр баригдаж ашиглалтад орсон нийт 969,582,479 төгрөгийн өртөг бүхий 6 барилга байгууламжийг /Сонгинохайрхан дүүрэгт 5 ус түгээх байр, Толгойтын усан сан/
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020.05.19-ний өдрийн 88 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2020.05.28-ны өдрийн А/742 дугаар захирамжаар Баянзүрх дүүрэг, Сүхбаатар дүүрэг, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт болон буцалтгүй тусламжаар баригдаж ашиглалтад орсон нийт 16 142 642 815 төгрөгийн өртөг бүхий 5 барилга байгууламжийг /Баянзүрх дүүргийн түлшний агуулах, Баянзүрх дүүрэг, Хан-Уул дүүргийн хүүхдийн эмнэлгүүд, 14-р сургууль, 24-р цэцэрлэгийн барилга/





- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020.06.16-ны өдрийн 98 дугаар тогтоолоор нийслэлийн төсвийн хөрөнгөөр баригдаж ашиглалтад орсон нийт 7,213,075,884 төгрөгийн өртөг бүхий ЧД-ийн 7-р хороо, Баянхошууны Хөтөл орчмын Дэд бүтцийн төвийн барилга байгууламж, шугам сүлжээг
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020.06.16-ны өдрийн 99 дүгээр тогтоолоор Чингэлтэй дүүргийн 7, 15, 19-р хорооны нутаг дэвсгэрт улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон нийт 4,739,555,019 төгрөгийн өртөг бүхий 4 барилга байгууламжийг /Чингэлтэй дүүргийн 15-р хорооны нутаг дах халаалтын зуухны барилга, 102-р цэцэрлэгийн өргөтгөл, Хайрхан хөгжлийн төв-2, Гүнтийн хяналт шалгалтын постны барилга/





- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020.06.16-ны өдрийн 100 дугаар тогтоолоор Баянгол дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг, Хан-Уул дүүрэг, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон нийт 15,831,694,838 төгрөгийн өртөгтэй сургууль, цэцэрлэгийн өргөтгөлийн 12 барилга байгууламжийг /13, 9, 52, Ирээдүй 1-р бага сургуулийн давхар нэмсэн өргөтгөл, Ирээдүй 2-р бага сургуулийн спорт заал, 116, 113, 73, 53, 103-р цэцэрлэгийн өргөтгөл, 23, 50-р сургуулийн өргөтгөл/,
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020.06.16-ны өдрийн 101 дүгээр тогтоолоор БНД, СХД-ийн нутаг дэвсгэрт улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар болон "УБ хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл 1"-ийн хүрээнд Азийн Хөгжлийн банкны хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр баригдаж ашиглалтад орсон нийт 7,709,370,434.27 төгрөгийн өртөгтэй 3 барилга байгууламжийг /Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсийн барилга, Сонгинохайрхан дүүргийн 261-р цэцэрлэгийн барилга, 9-р сургуулийн спорт заалны барилга
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 121 дүгээр тогтоолоор нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон нийт 4,063,494,530 төгрөгийн өртөг бүхий 47 орон сууц /"Нийслэлийн Орон сууцны корпораци" ХК/
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 137 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын А/1100 дугаар захирамжаар Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон 494,463,727 төгрөгийн өртөг бүхий Ахмадын өргөөний барилга/-ийг
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдтйг хурлын Тэргүүлэгчдийн 2020.11.06-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Турк улсын буцалтгүй тусламжаар НД-ийн 7-р хороо, ЧД-ийн 17-р хорооны нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон нийт 1,005,671,337 төгрөгийн өртөг бүхий ӨЭМТ-ийн 2 барилгыг, тус тус нийслэлийн өмчид бүртгэх буюу эзэмшигч байгууллагуудад данс бүртгэлдээ бүртгэн, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллаж, тогтоол, захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг эзэмшигч байгууллагуудад албан бичгээр даалгасан. 13 дугаар сургууль, 103 цэцэрлэг/





*<u>Хоёр. Тээврийн хэрэгсэл –</u>* **16,877.1** ***<u>сая төгрөг</u>*** *<u>/174 ш/</u>*

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/84 дүгээр захирамжаар 2 156,1 сая төгрөгийн 5, А/215 дугаар захирамжаар 476,1 сая төгрөгийн 10, А/371 дүгээр захирамжаар 81,8 сая төгрөгийн 5, А/579 дүгээр захирамжаар 2 152,0 сая төгрөгийн 12, А/741 дүгээр захирамжаар 656,0 сая төгрөгийн 7, А/811 дүгээр захирамжаар 320,8 сая төгрөгийн 4, А/812 дугаар захирамжаар 173,5 сая төгрөгийн 2, А/985 дугаар захирамжаар 597,7 сая төгрөгийн 6, А/990 дүгээр захирамжаар 1 923,5 сая төгрөгийн 14, А/1161 дүгээр

захирамжаар 99,5 сая төгрөгийн 1, А/1162 дугаар захирамжаар 602,7 сая төгрөгийн 14, А/1190 дүгээр захирамжаар 1 154,0 төгрөгийн 6, А/1193 дугаар захирамжаар 1 159,6 сая төгрөгийн 8, А/1217 дугаар захирамжаар 1 036,0 сая төгрөгийн 7, А/1218 дугаар захирамжаар 4 287,8 сая төгрөгийн 73, нийт 16 877,1 сая төгрөгийн үнэтэй 174 тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчид бүртгэх 15 захирамжийг гаргуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.

*Дөрөв. Шинээр бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авах тухай албан бичиг хүргүүлсэн байдал –***38,715.1** *сая төгрөг*

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар болон төсөл хэрэгжсэн байгууллагуудаас ирүүлсэн улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгөөр бий болсон шугам сүлжээ, автозам, тохижилт, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг нийслэлийн өмчид бүртгүүлэх хүсэлтийг үндэслэн шинээр бий болсон 258 төсөл арга хэмжээний нийт ***38 715,1 сая*** төгрөгийн эд хөрөнгийг данс бүртгэлдээ тусгаж, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг даалгасан 1 тушаал, 151 албан бичгийг өмч эзэмшигч 104 байгууллагад хүргүүлсэн байна.

Инженерийн шугам сүлжээтэй холбоотой 5 төсөл арга хэмжээний 2 007,0 сая төгрөгийн хөрөнгийн бүртгэлийн асуудлыг шийдвэрлэсэн байна.

Төсвийн хөрөнгөөр шинээр бий болсон 11 980,4 сая төгрөгийн хөдлөх хөрөнгийг холбогдох журмын дагуу байгууллагын даргын тушаалаар бүртгэлд авсан тухай албан бичгийг 87 байгууллагаас тушаалын хуулбарын хамтаар ирүүлснийг холбогдох судалгаанд оруулав.

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөрөнгийн сан, замын сангийн хөрөнгөөр 2020 онд санхүүжих хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай Нийслэлийн Засаг даргын 192 захирамжийг хүлээн авч 989 төсөл арга хэмжээ бүхий төсөл арга хэмжээний судалгааг гаргаж, холбогдох нэмэлт өөрчлөлтүүдийг хийж оруулсан. 2020 онд санхүүжигдэх дүнгээр давхардсан байдлаар авч үзвэл:

- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх – 204,164.7 сая төгрөгийн 397 ажил,
- Замын сангийн хөрөнгөөр хийгдэх – 51,562.9 сая төгрөгийн төгрөгийн 113 ажил,
- Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих – 22,209.4 сая төгрөгийн 287 ажил,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх – 94,294.1 сая төгрөгийн 192 ажлын судалгааг гаргасан.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын дагуу ажилласан улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын буцалтгүй тусламжаар санхүүжигдсэн барилга байгууламж, тохижилтын ажлыг хүлээн авч, байнгын ашиглалтад оруулах 282 комиссын бүрэлдэхүүнд холбогдох мэргэжилтнүүд ажиллаж, саналаа өгсөн байна.

### *3.2.2. Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн талаар*

#### А. Барилга байгууламж балансаас балансад шилжүүлэх

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 5.2-т заасны дагуу үл хөдлөх хөрөнгийн балансаас балансад шилжүүлэх нийт **10** байгууллагын

**18,063.1** сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий **13** барилга байгууламжийн танилцуулга бичиж, тогтоолын төсөл боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох дарга нараас санал авч, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Үүнд:

- Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй Баянзүрх дүүргийн 14-р хороонд байрлах Консулын дэнжийн нууц булгэмийн 6,1 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилгыг Нийслэлийн Соёл, урлагийн газрын балансад,
- Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн балансад бүртгэлтэй 138,9 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий уурын зуухны барилгыг Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын балансад,
- Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй нийт 155,3 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 13 барилгыг "Налайх Ахмадын амралт, сувилал" ОНӨААТҮГ-ын балансад,
- Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй нийт 55,8 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий "Нарны эрч" ӨЭМТ-ийн барилгыг Налайх дүүргийн Гэрэлтүүлэг чимэглэлийн алба ОНӨААТҮГ-ын балансад,
- Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори "Ирээдүй" цогцолбор сургуулийн балансад бүртгэлтэй нийт 5,670,7 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийг Нийслэлийн ерөнхий боловсролын "Хөгжил" цогцолбор сургуулийн балансад, нийт 5 721,5 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийг Нийслэлийн ерөнхий боловсролын "Өнөр" цогцолбор сургуулийн балансад,
- Нийслэлийн Баянгол дүүргийн 4, 6, 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт тус тус байрлах Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй нийт 5 799,9 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тус дүүргийн "Хүүхэд, залуучуудын соёлын ордон", "Гэр бүл, ёслолын ордон", "Усан спорт сургалтын төв" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын балансад,
- Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй 23,9 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга, байгууламжийг Багахангай дүүргийн Дотоод аудитын газрын балансад,
- Багахангай дүүргийн 44 дүгээр цэцэрлэгийн балансад бүртгэлтэй нийт 434,9 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийг Багахангай дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн балансад тус тус шилжүүлэхээр шийдвэрлүүлсэн байна.
- Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газар, Цагдаагийн хэлтсийн балансад тус тус бүртгэлтэй нийт 2 барилга байгууламжийг Баянзүрх дүүргийн 16 дугаар цэцэрлэгийн балансад шилжүүлсэн.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 70 дугаар тогтоолоор Хан-Уул дүүргийн 4,8 дугаар хорооны нутаг дэвсгэрт Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилга баригдаж байгаатай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 100 дугаар тогтоолыг хүчингүй болгохоор шийдвэрлэсэн.

Б. Тээврийн хэрэгсэл балансаас балансад шилжүүлэх

Нийслэлийн Засаг даргын **11** удаагийн захирамжаар нийт **1,293.6** сая төгрөгийн тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

### *3.2.3. Данснаас хассан хөрөнгийн талаар:*

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4.2-т заасны дагуу Барилга байгууламжийн ашиглалтын болон байгалийн хүчин зүйлээс хамаарч үндсэн хийц бүтээцэд хэвийн хэмжээнээс илүү ан цав үүсэж, илт эвдрэл, гэмтэлтэй, үндсэн бүтээц хийцэд өөрчлөлт орсон нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр батлагдсан 19 байгууллагын нийт **6,036,146,528.12** төгрөгийн үнэ бүхий 25 барилга байгууламжийг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тогтоолын төсөл боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох дарга нараас санал авч, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж хурлын тогтоолоор баталгаажуулан, хэрэгжилтийг ханган ажилласан байна. Үүнд:

- Налайх дүүргийн Цагдаагийн хэлтсийн балансад бүртгэлтэй нийт 144,724 336,98 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эрүүлжүүлэх байрны барилга, автомашины гараашийн барилга,
- Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй тус дүүргийн 23 дугаар хороонд байрлах 29,676,300 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий нийтийн бие засах газрын барилга,
- Баянзүрх дүүргийн 16 дугаар хороонд байрлах "Бяцхан тэмүүлэл" төвийн балансад бүртгэлтэй нийт 293,456,466.88 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгө,
- Баянзүрх дүүргийн 16 дугаар хороонд байрлах 8 дугаар цэцэрлэгийн балансад бүртгэлтэй 401,193,625.00 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгө,
- Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй 86,474,406.0 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий, Баянгол дүүргийн Прокурорын газар байрлан үйл ажиллагаа явуулдаг барилгын 1 дүгээр давхрын хэсэг
- Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 84 дүгээр цэцэрлэгийн балансад бүртгэлтэй нийт 317,013,055.20 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга байгууламж,
- Хан-Уул дүүргийн 71 дүгээр цэцэрлэгийн балансад бүртгэлтэй 4,775,660.80 төгрөгийн үнэ бүхий цэцэрлэгийн өргөтгөлийн барилга
- Хан-Уул дүүргийн 26-р сургуулийн балансад бүртгэлтэй 4,250,080.00 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий жижиг барилга,
- Хан-Уул дүүргийн 10-р сургуулийн балансад бүртгэлтэй 132,867,127.56 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгө,
- Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын балансад бүртгэлтэй Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороонд байрлах нийт 49,480,453 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хуучин 3 барилга,
- Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй Хан-Уул дүүргийн 12 дугаар хороонд байрлах нийт 235,611,829 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий амралтын байр /шатсан/

- Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороонд байрлах 61 дүгээр сургуулийн балансад бүртгэлтэй нийт 3,289,481 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хичээлийн хуучин байрны барилга,
- Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй нийт 27,846,333 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий "Ачлал налайх" ОЭМТ-ийн хуучин барилга,
- Налайх дүүргийн 2 дугаар хороонд байрлах Голомт цогцолбор сургуулийн балансад бүртгэлтэй нийт 1,421,660,527 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга байгууламж,
- Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороонд байрлах Нийслэлийн Онцгой байдлын газрын балансад бүртгэлтэй нийт 1,986,391,885 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга байгууламж,
- Сүхбаатар дүүргийн 149 дүгээр цэцэрлэгийн балансад бүртгэлтэй 313,4 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай,
- Сүхбаатар дүүргийн 14-р хороо, Хангайн 43 дугаар гудамжинд байрлах 9,458,527.68 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 75-р ус түгээх байр
- Сүхбаатар дүүргийн 17-р хороо, Дамбадаржаагийн 60-р гудамжинд байрлах 613,948.61 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 85 дугаар ус түгээх байр,
- Чингэлтэй дүүргийн 14-р хороо, Зүрх уулын гудамжинд байрлах 3,663,880.23 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 165 дугаар ус түгээх байр,
- Сонгинохайрхан дүүргийн 8-р хороо, Нуурын 8-р гудамжинд байрлах 5,920,606.86 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 252 дугаар ус түгээх байр,
- Хан-Уул дүүргийн 6-р хороо, Нүхтийн 29-р гудамжинд байрлах 1,294,329.20 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 315 дугаар ус түгээх байр,
- Баянзүрх дүүргийн 16-р хороо, Цайзын 72-р хотхоны хажууд байрлах 2,747,329.20 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 23 дугаар ус түгээх байр,
- Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй, ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон 226,395,624 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий салбар амбулаторын барилга-1
- Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй, ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогдоогдсон 181,076,677,86 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий салбар амбулаторийн барилга,
- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо, Урт цагаан үйлчилгээний төвийн 1 дүгээр корпусын 295,364,995.0 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга байгууламж.



### *3.2.4. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын хурлыг зохион байгуулах:*

Газрын даргын 2019 оны А/578 дугаар тушаалаар батлагдсан "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын ажиллах журмын дагуу 15 удаа хурал зохион байгуулж давхардсан тоогоор 480 байгууллагын 15579 нэр төрлийн 25,620,023,046 төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг хэлэлцүүлэн, гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

Үүнд:

а/ Шинээр худалдаж авах хөрөнгө: 20 байгууллагын 740,648,538.0 төгрөг

б/ Бүртгэх хөрөнгө: 38 байгууллагын 2,352,298,715.2 төгрөг

в/ Балансаас балансад шилжүүлэх хөрөнгө: 30 байгууллагын 1,922,305,482.0 төгрөг

г/ Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгө: 37 байгууллагын 464,548,465.2 төгрөг

д/ Данснаас хасах хөрөнгө: 127 байгууллагын 20,138,096,846.1 төгрөг

е/ Дахин үнэлсэн хөрөнгө: 1 байгууллагын 2,125,000 төгрөг

Хөрөнгийн хөдөлгөөний дүнг улирал бүрээр харуулбал:

| Улирал | Худалдан авах | Хөрөнгө бүртгэх | Балансаас балансад шилжүүлэх | Данснаас дансанд шилжүүлэх | Данснаас хасах | Дахин үнэлсэн хөрөнгө | Нийт байгууллагын тоо | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1-р улирал | 97,894,000 | 221,113,492 | 239,535,955 | 141,650,730 | 10,075,518,271 | 2,125,000 | 77 | 10,777,837,449 |
| 2-р улирал | 234,869,655 | 528,380,309 | 1,556,395,307 | 321,713,735 | 7,212,903,892 | | 253 | 9,854,262,899 |
| 3-р улирал | 281,424,348 | 1,122,705,352 | 73,745,808 | 1,184,000 | 1,700,875,567 | | 76 | 3,179,935,075 |
| 4-р улирал | 126,460,535 | 480,099,561 | 52,628,412 | | 1,148,799,115 | | 74 | 1,807,987,624 |
| Нийт дүн | **740,648,538** | **2,352,298,715** | **1,922,305,482** | **464,548,465** | **20,138,096,846** | **2,125,000** | **480** | **25,620,023,046** |

ЭБХХХК-ын 15 удаагийн хурлын хөрөнгийн хөдөлгөөний дүнг хурал бүрээр харуулбал:



Нийт шийдвэрлэсэн хөрөнгийн дансны харьцуулалтыг харуулбал:

/мян.төг/




ЭБХХХК нь давхардсан тоогоор 252 байгууллагын 20,138,096,846 төгрөгийн хөрөнгө данснаас хасах хүсэлтийг хэлэлцэж газрын даргын 229 тушаалын төсөл хяналт тавьж ажилласан.

Данснаас хасах хөрөнгийн дүнг хүснэгтээр харуулбал:

| д/д | Хурлын огноо | Тушаалын тоо | Данснаас хасах дүн | Татан төвлөрүүлэх дүн | Усгтах хөрөнгийн дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2020.02.07 | 3 | 134,345,598.50 | 110,458,498.10 | 23,887,100.40 |
| 2 | 2020.02.20 | 11 | 248,056,643.84 | 195,788,713.14 | 52,267,930.70 |
| 3 | 2020.03.06 | 8 | 9,051,833,422.00 | 5,135,419,924.00 | 3,916,413,498.00 |
| 4 | 2020.03.19 | 11 | 294,925,661.20 | 101,515,745.20 | 193,409,916.00 |
| **Дүн** | | **33** | **9,729,161,326** | **5,543,182,880** | **4,185,978,445** |
| 1 | 2020.04.03 | 8 | 1,715,005,084.58 | 863,514,730.58 | 851,490,354.00 |
| 2 | 2020.04.21 | 28 | 1,462,946,060.02 | 1,285,389,644.06 | 177,556,415.96 |
| 3 | 2020.05.04 | 11 | 732,753,604.73 | 267,173,477.26 | 465,580,127.47 |
| 4 | 2020.05.20 | 7 | 103,124,118.97 | 48,457,565.41 | 54,666,553.56 |
| 5 | 2020.06.04 | 31 | 1,503,021,009.25 | 1,130,860,985.15 | 372,160,024.10 |
| 6 | 2020.06.29 | 47 | 1,549,472,311.34 | 1,308,572,113.71 | 240,900,197.63 |
| **Дүн** | | **132** | **7,066,322,188.89** | **4,903,968,516.17** | **2,162,353,672.72** |
| 1 | 2020.07.30 | 12 | 985,701,033.78 | 953,957,338.78 | 31,743,695.00 |
| 2 | 2020.09.02 | 11 | 309,959,445.68 | 220,233,818.81 | 89,725,626.87 |
| 3 | 2020.09.23 | 10 | 403,970,088.10 | 270,087,850.00 | 133,882,238.10 |
| **Дүн** | | **33** | **1,699,630,567.56** | **1,444,279,007.59** | **255,351,559.97** |
| 1 | 2020.10.20 | 18 | 833,525,966.13 | 636,214,385.59 | 197,311,580.65 |
| 2 | 2020.12.04 | 13 | 315,113,149.49 | 270,166,816.49 | 44,946,333.00 |
| **Дүн** | | **31** | **1,148,639,115.62** | **906,381,202.08** | **242,257,913.65** |
| Нийт дүн | | **229** | **19,643,753,197.61** | **12,797,811,606.28** | **6,845,941,591.44** |

### *3.2.5. Нийслэлийн өмчийн мэдээллийн сангийн баяжилтын талаар:*

Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой 772 байгууллагын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч хянан, "Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем"-д хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлтийг тусган, баяжилт хийсэн болно. Төрийн Өмчийн бодлого зохицуулалтын газар болон Үндэсний Статистикийн газарт 772 байгууллагын өмчийн бүртгэлийн дүн мэдээг ТӨ болон ТӨХ маягтуудын дагуу тайлагнаж хүргүүлэв. 2019 оны жилийн эцсийн балансаар нийт хөрөнгө

4.110.213.8 сая төгрөг үүнээс эргэлтийн бус хөрөнгө 3.176.392.7 сая төгрөг, эргэлтийн хөрөнгө 933.821.1 сая төгрөг байна.

| д/д | Хөрөнгийн төрөл | 2016 он | 2017 он | 2018 он | 2019 он |
|---|---|---|---|---|---|
| 1 | Байгууллагын тоо | 733 | 758 | 770 | 772 |
| 2 | Эргэлтийн хөрөнгө | 157,060,821.90 | 506,704,524.7 | 603,807,014.5 | 933,821,035.4 |
| 3 | Эргэлтийн бус хөрөнгө | 1,217,054,990.90 | 1,581,182,482,7 | 3,219,405,800.1 | 3,176,392,780.5 |
| 4 | Нийт хөрөнгө | **1,374,115,812.8** | **2,087,887,007.5** | **3,823,212,814.6** | **4,110,213,815.9** |




### *3.2.6.Өмч хувьчлалын ажлын талаар:*

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 29/32 дугаар тогтоолоор 5 барилга байгууламж, нийслэлийн оролцоотой 1 хуулийн этгээдийн нийслэлийн мэдлийн хувийг хувьчлахаар шийдвэрлэж, нийслэлийн төсөвт өмч хувьчлалаас 68 363,3 сая төгрөг төвлөрүүлэхээр шийдвэрлэснийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 29/36 дугаар тогтоолоор 73 363,3 сая төгрөг болгон өөрчлөлт оруулсны дагуу хувьчлалын ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Өмч хувьчлалын үйл ажиллагааны зардалд зориулан Нийслэлийн Засаг даргын А/220 дугаар захирамжаар 733,6 сая төгрөгийг Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргах шийдвэр гаргуулсан байна.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020.04.30-ны өдрийн хурлаар дараахь 2 асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэв.
Үүнд: Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо, хуучнаар Баруун сэлбэ үйлчилгээний төвийн "Ж" блокийн 1220 м2 талбайтай байр, Багануур дүүргийн 2 дугаар хорооны хуучин барилгыг хувьчлах арга хэлбэрийг тогтоох асуудлыг хэлэлцүүлж, "Ж" блокийг Иргэний хуулийн хуулийн 105 дугаар зүйлийн дагуу "Улаанбаатар радио" ХХК-д тэргүүн ээлжинд санал болгох, хорооны хуучин барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар хувьчлахаар 60 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Мөн нийслэлийн өмчөөс хувьчлах эд хөрөнгийн жагсаалтад байсан ХУД-ийн 13-р хорооны Захирагчийн албаны 2 барилга, ХИХУГ-ын байр, БЗД-ийн 9-р хорооны хуучин барилга, Цагдаагийн хэсгийн барилга гэсэн 4 барилгыг хувьчлалын жагсаалтаас хасах 59 дүгээр тогтоолыг гаргуулав.

Тайлант онд дараахь барилга байгууламжуудын үнэлгээний тайланг хүлээн авах, үнэлгээ хийлгэх гэрээ байгуулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

| № | Үнэлгээ хийх барилга байгууламжийн нэр | Гэрээ байгуулсан огноо | Гэрээний дугаар | Гэрээний дүн | Үнэлгээ хийсэн ААНБ | Үнэлгээний тайланг хүлээн авсан огноо |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | "Хишиг Уул" ХК-ийн нийслэлийн өмчлөлийн 34 хувь | 2019.12.05 | 01/2019 | 9,800,000 | "Эрдэнэс экаунтинг энд консалтинг" ХХК | 2020.01.15 |
| 2 | 50-р дэлгүүрийн өргөтгөл | 2012.12.11 | 02/2019 | 9,800,000 | "Үнэлгээ консалтинг" ХХК | 2020.02.28 |
| 3 | Баянгол дүүргийн 8-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга | 2019.12.11 | 03/2019 | 4,000,000 | "Золач" ХХК | 2020.01.28 |
| 4 | Баянгол дүүргийн 1-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга | | | | | |
| 5 | "Монгол шуудан" ХК-ийн 26-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр | | | | | |
| 6 | "Монгол шуудан" ХК-ийн 20-р салбарын түрэсээр эзэмшиж буй байр | | | | | |
| 7 | Баруун сэлбэ үйлчилгээний төвийн Ж блок буюу Улаанбаатар радио ХХК байрлаж байгаа 1220м2 талбай бүхий байр | 2020.05.07 | 01/2020 | 2,749,500 | "Үнэлгээ консалтинг" ХХК | 2020.05.13 |
| 8 | Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын хуучин барилга | 2020.10.28 | 08/2020 | 6,072,000 | "Золач" ХХК | 2020.11.20 |
| 9 | Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын өргөтгөлийн барилга | 2020.10.28 | 09/2020 | 3,800,000 | "Ю би пропертиз" ХХК | 2020.11.12 |
| 10 | ХИХУГ-ын харьяа "Ану сервис" ХХК-ийн менежментийн гэрээгээр ажиллуулж буй 8 халаалтын зуухны барилга | 2020.10.28 | 10/2020 | 9,900,000 | "Профейшнл коннекшн" ХХК | 2020.11.17 |

"Төв цэнгэлдэх хүрээлэн" ХХК-ийн нийслэлийн өмчлөлийн 49 хувийг хувьчлахтай холбогдуулан компанийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг хийх зөвлөхийн үйлчилгээний тендер шалгаруулалтыг явуулахаар Газрын даргын 2020.05.18-ны өдрийн А/215 дугаар тушаалаар Үнэлгээний хороог байгуулсан. Ажлын даалгавар боловсруулан санал ирүүлэх урилгыг "Өдрийн сонин", "Өнөөдөр" сонины 2020.05.21-ний дугаарт нийтлүүлж, төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулсан. Урилгын дагуу 7 компаниас тендерт оролцохоор саналаа ирүүлсэн боловч захиалагчаас тавьсан шаардлага болзлыг 6 компани хангаагүй тул хуулийн дагуу дахин зарлахаар Үнэлгээний хорооноос шийдвэрлэсэн. Хоёр дах удаагийн зарыг 2020.06.30-нд нийтлүүлж, 2020.07.17-нд нээсэн ба 4 компани санал ирүүлсэн боловч шаардлага хангасан хуулийн этгээд байгаагүй болно. Гурав дахь удаагийн зарыг 2020.10.19-нд дахин нийтлүүлж, 2020.10.29-нд нээсэн бөгөөд 5 компани санал ирүүлсэн. Үнэлгээний хороо хураангуй жагсаалтыг гаргаж, компаниудад урилгаа хүргүүлсэн. Тендерийг 2020.12.10-нд нээж үнэлэх байсан боловч 2020.11.11-ний өдрөөс гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор тендерт оролцогчдод тендер хүлээн авах, нээх хугацааг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсныг 2020.12.07-ны өдрийн 3/2031 дүгээр албан бичгээр мэдэгдээд байна.





Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлгийн "Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах гэрээний үлгэрчилсэн загвар"-ыг НИТХТ-ийн 2020.07.31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, "Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай" 127 дугаар тогтоолоор батлуулсан.

*<u>Нийслэлийн өмчөөс 2021 онд хувьчлах эд хөрөнгийн талаар:</u>*

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн харьяа агентлаг нийт 49 байгууллагаас санал авч "Хувьчлах эд хөрөнгийн жагсаалт"-ын төслийг боловсруулсан. Нийслэлийн өмчлөлд зайлшгүй байх шаардлагатай эсэх, ашиглалтын өнөөгийн түвшин, цаашид ашиглах хэрэгцээ шаардлага зэргийг харгалзан 9 барилга байгууламжийг хувьчлах тухай Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулсан.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020.12.04-ний өдрийн 02/13 дугаар тогтоолоор нийслэлийн өмчөөс 2021 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг батлаад байна.

Нийслэлийн өмчөөс 2021 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалт

| № | Хувьчлагдах хуулийн этгээд, эд хөрөнгийн нэр, байршил | Байршил | Хувьчлалын арга хэлбэр |
|---|---|---|---|
| 1 | Хар үнэгний аж ахуйн барилга байгууламж | ХУД-ийн 13-р хороо | Нээлттэй дуудлагын худалдаа |
| 2 | Өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга | БЗД-ийн 12-р хороо | Нээлттэй дуудлагын худалдаа |
| 3 | "Монгол шуудан" ХК-ийн 44-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр | СБД-ийн 4-р хороо | Иргэний хуулийн 105 дугаар зүйлийн дагуу |
| 4 | "Монгол шуудан" ХК-ийн 36-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр | ХУД-ийн 3-р хороо | Иргэний хуулийн 105 дугаар зүйлийн дагуу |
| 5 | Халуун усны барилга | СБД-ийн 15-р хороо | Нээлттэй дуудлагын худалдаа |
| 6 | Халуун усны барилга | СБД-ийн 16-р хороо | Нээлттэй дуудлагын худалдаа |
| 7 | Халуун усны барилга | СБД-ийн 18-р хороо | Нээлттэй дуудлагын худалдаа |
| 8 | Халуун усны барилга | ХУД-ийн 16-р хороо | Нээлттэй дуудлагын худалдаа |

### *3.2.7.Барилга байгууламжийн дуудлага худалдааны талаар:*

Нээлттэй дуудлагын худалдааг 2020 онд 9 удаа нийтэд зарлаж, дуудлага худалдааны зар мэдээг "Өдрийн сонин", "Өнөөдөр", "Үндэсний шуудан", "Монголын үнэн"

зэрэг өдөр тутмын сониноор нийтэд зарлаж, Өмчийн ашиглалт, удирдлагын газрын "Umch.ub.gov.mn" сайтад байршуулсан. Мөн томоохон барилга байгууламжууд дээр видео зар сурталчилгааг хийлгэн UBS, TV9, SBN,TM, OTV, NTV,C1 зэрэг телевизээр өдрийн 2-3 удаагийн давтамжтайгаар явуулах, Мобиком корпарацитай маркетингийн гэрээ байгуулан мессэж зарыг 9911, 9909 дугаарын хэрэглэгчдэд хүргэх зэрэг арга хэмжээ авч ажилласан болно.

1. Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр буюу Бизнес хөгжлийн төвийн барилгын дуудлагын худалдааг 2020.02.10-ны өдөр зохион байгуулахаар нийтэд зарласан боловч оролцогчийн санал ирээгүй.
2. Хуучнаар "Автобус-3" НӨҮГ-ын барилга байгууламжийн дуудлагын худалдааг 2020.03.17-ны өдөр зохион байгуулахаар нийтэд зарласан боловч оролцогчийн санал ирээгүй.
3. СБД-ийн 16-р хороо, ХУД-ийн 12-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга болон БГД-ийн 10-р хорооны хуучин барилгын дуудлагын худалдааг 2020.04.23-ны өдөр зохион байгуулахаар нийтэд зарласан ба Хан-Уул дүүргийн 12-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилгыг "Энэрэл нигүүсэл оюун билгийн төв" ТББ 62,4 сая төгрөгөөр хувьчилж авсан.





4. СБД-ийн 16-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга, "Монгол шуудан" ХК-ийн 26-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр болон "Монгол шуудан" ХК-ийн 23-р салбарын түрээсээр эзэмшиж байсан байрны 2 дугаар хэсгийн дуудлагын худалдааг 2020.06.02-ны өдөр зохион байгуулахаар нийтэд зарласан ба "Монгол шуудан" ХК-ийн 23-р салбарын түрээсээр эзэмшиж байсан байрны 2 дугаар хэсгийг иргэн С.Эрдэнэ 254,0 сая төгрөгөөр хувьчилж аваад байна.






5. Хуучнаар "Автобус-3" НӨҮГ-ын барилга байгууламж, Хишиг-Уул" ХК-ийн нийслэлийн өмчлөлийн 34 хувь, Баянгол дүүргийн дүүргийн 10-р хорооны хуучин барилгын дуудлагын худалдааг 2020.06.03-ны өдөр зохион байгуулахаар нийтэд зарласан ба хуучнаар "Автобус-3" НӨҮГ-ын барилга байгууламжийг "Камдер" ХХК 20 020,0 сая

төгрөгийн, Баянгол дүүргийн дүүргийн 10-р хорооны хуучин барилгыг иргэн Х.Гантулга 15,2 сая төгрөгийн үнийн санал хэлж, ялагч болон "Худалдах худалдан авах гэрээ"-г байгуулаад байна.




6. Сүхбаатар дүүргийн 16-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга, "Монгол шуудан" ХК-ийн 26-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр, Хишиг-Уул" ХК-ийн нийслэлийн өмчлөлийн 34 хувийг хувьчлах дуудлагын худалдааг 2020.06.25-ны өдөр зохион байгуулахаар зарласан ба оролцогчийн санал ирээгүй.
7. Сүхбаатар дүүргийн 16-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга, "Монгол шуудан" ХК-ийн 26-р салбарын түрээсээр эзэмшиж буй байрыг хувьчлах дуудлагын худалдааг 2020.09.22-ны өдөр зохион байгуулахаар нийтэд зарласан ба СБД-ийн 16-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилгыг иргэн Ц.Ундрах 35,0 сая төгрөгөөр хувьчилж авсан.




8. Нийслэлийн Засаг захиргааны "Хангарди" ордны барилгын нээлттэй дуудлагын худалдааг 2020.11.20-ны өдөр зохион байгуулахаар зарласан боловч нийслэлийн удирдлагуудаас өгсөн чиглэлийн дагуу дуудлагын худалдааг тодорхойгүй хугацаагаар хойшлуулах зарыг өгсөн.
9. Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт орших 50-р дэлгүүрийн өргөтгөлийн барилгыг хувьчлах нээлттэй дуудлагын худалдааг 2020.12.10-ны өдөр зохион байгуулахаар нийтэд зарлаад байсан боловч КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор дуудлагын худалдааг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан тухай мэдэгдлийг 2020.12.04-ний өдрийн Өнөөдөр, Өдрийн сонин, Үндэсний шуудан сонины дугааруудад нийтлүүлж, байгууллагын цахим хуудаст байршуулаад байна.

*Нийслэлийн өмч хувьчлах комиссын хурал*

Нийслэлийн Өмч хувьчлах комиссын хурлыг 5 удаа /2020.02.07, 2020.04.01, 2020.05.15, 2020.07.08, 2020.07.30/ зохион байгуулж, 34 тогтоол гаргуулж ажилласан байна. Үүнд:

- Шинээр хувьчлах тухай - 11,
- Өмчлөгчийн эрх олгох тухай - 7,
- Хувьчлалын тайлан батлах тухай - 6,
- Дахин дуудлагын худалдаагаар хувьчлах тухай - 4,
- Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах тухай - 5

2020 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн хурал /12 асуудал хэлэлцүүлж, 9 тогтоол/

1. *Шинээр хувьчлах*
   - Нийслэлийн Засаг захиргааны "Хангарьд" ордны барилга
   - СБД-ийн 10-р хорооны халуун усны барилга
   - БЗД-ийн Цагдаагийн 3-р хэлтсийн Шархадны хэсгийн хуучин барилга
   - СБД-ийн 16-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга
   - "Монгол шуудан" ХК-ийн эзэмшиж буй байрын 2 дугаар хэсэг
   - ХУД-ийн 12-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга
2. *Дахин дуудлагын худалдаагаар хувьчлах*
   - Хуучнаар "Автобус-3" НӨҮГ-ын барилга байгууламж
   - БГД-ийн 10-р хорооны хуучин барилга
   - БЗД-ийн 9-р хорооны хуучин барилга
3. *Өмчлөгчийн эрх олгох тухай*
   - СХД-ийн 20-р хорооны халуун усны барилга
   - "Монгол шуудан" ХК-ийн 23-р салбарын эзэмшиж буй байр
4. *Хувьчлалын тайлан батлах тухай*
   - ХУД-ийн Цагдаагийн түр саатуулах байрлаж байсан барилга

2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хурал /10 асуудал хэлэлцүүлж, 5 тогтоол/

1. *Шинээр хувьчлах*
   - "Монгол шуудан" ХК-ийн 26-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр
   - "Монгол шуудан" ХК-ийн 20-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр
2. *Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах*
   - "Чандмань Налайх" ОНӨААТҮГ-ын Ахуйн үйлчилгээний төв
3. *Дахин дуудлагын худалдаагаар хувьчлах*
   - Хуучнаар "Автобус-3" НӨҮГ-ын барилга байгууламж
   - "Хишиг-Уул" ХК-ийн нийслэлийн өмчлөлийн 34 хувь
4. *Хувьчлалын тайлан батлах тухай*
   - СХД-ийн 20-р хорооны халуун усны барилга
   - "Монгол шуудан" ХК-ийн 23-р салбарын эзэмшиж буй байр
5. *Танилцуулга /Хувьчлалын жагсаалтаас хасах тухай/*
   - ХИХУГ-ын эзэмшиж буй байр
   - СБД-ийн 9 дүгээр хорооны хуучин байр
   - ХУД-ийн 13-р хороо, Захирагчийн ажлын албаны 2 барилга

2020 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хурал /11 асуудал хэлэлцүүлж, 9 тогтоол/

1. *Танилцуулга*

- Нийслэлийн Засаг захиргааны "Хангарьд" ордны барилга
- "СХД-ийн 21-р хорооны агуулахын барилга

2. *Өмчлөгчийн эрх олгох тухай*
   - "Монгол шуудан" ХК-ийн 20-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр
   - ХУД-ийн 12-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга
3. *Дахин дуудлагын худалдаагаар хувьчлах*
   - Хуучнаар "Автобус-3" НӨҮГ-ын барилга байгууламж
   - "Хишиг-Уул" ХК-ийн нийслэлийн өмчлөлийн 34 хувь
   - БГД-ийн 10-р хорооны хуучин барилга
4. *Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах*
   - "Үртсэн шахмал түлшний үйлдвэр" ОНӨААТҮГ
   - Багахангайн мах боловсруулах үйлдвэр" ОНӨААТҮГ
5. *Шинээр хувьчлах*
   - 50-р дэлгүүрийн өргөтгөлийн барилга
   - Баруун сэлбэ үйлчилгээний төвийн "Ж" блокийн байр

2020 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн хурал /7 асуудал хэлэлцүүлж, 7 тогтоол/

1. *Шинээр хувьчлах*
   - Багануур дүүргийн 2-р хорооны хуучин барилга
2. *Өмчлөгчийн эрх олгох тухай*
   - Баруун сэлбэ үйлчилгээний төвийн "Ж" блок
   - "Монгол шуудан" ХК-ийн 23-р салбарын түрээсээр эзэмшиж байсан байрны 2-р хэсэг
   - Баянгол дүүргийн 10 дугаар хорооны хуучин барилга
3. *Дахин дуудлагын худалдаагаар хувьчлах*
   - СБД-ийн 16-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга
4. *Хувьчлалын тайлан батлах тухай*
   - "Монгол шуудан" ХК-ийн 20-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр
   - ХУД-ийн 12-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга

2020 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн хурал /3 асуудал хэлэлцүүлж, 3 тогтоол/

1. *Хувьчлалын тайлан батлах тухай*
   - "Монгол шуудан" ХК-ийн 23-р салбарын түрээсээр эзэмшиж байсан байрны 2-р хэсэг
2. *Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтын дүн батлах тухай*
   - "Үртсэн шахмал түлшний үйлдвэр" ОНӨААТҮГ
   - Багахангайн мах боловсруулах үйлдвэр" ОНӨААТҮГ

"Нийслэлийн өмч хувьчлах комисс"-ын ажиллах журмын 2.3 дах заалтыг үндэслэн хуралдааны бус хэлбэрээр 2 тогтоолыг албажуулан хэрэгжүүлж ажилласан. Үүнд: НӨХК-ын 2020.06.29-ны өдрийн "Өмчлөгчийн эрх олгох тухай" тогтоолоор хуучнаар "Автобус 3" НӨҮГ-ын барилга байгууламжийн өмчлөх эрхийг шинэ өмчлөгч "Камдер" ХХК-д шилжүүлэн олгох тухай, 2020.10.08-ны өдрийн "Хувьчлалын тайлан батлах тухай" тогтоолоор хуучнаар "Автобус 3" НӨҮГ-ын барилга байгууламжийг хувьчилсан тухай тайланг баталсан.





*Иргэний хуулийн 105-р зүйлийн дагуу тэргүүн ээлжинд санал болгон хувьчилсан байрууд*

Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020.04.01-ний өдрийн 01, 02 дугаар тогтоолоор Шуудангийн 20, 26 дугаар салбарын байрлаж буй байрыг хувьчлах үнийг тогтоож, Иргэний хуулийн 105 дугаар зүйлийн дагуу түрээсээр эзэмшиж буй "Монгол шуудан" ХК-д тэргүүн ээлжинд санал болгон хувьчлахаар шийдвэрлэсэн. Тогтоолын дагуу 2020.04.20 –ны өдрийн 3/844 дүгээр албан бичгээр "Монгол шуудан" ХК-д мэдэгдэл хүргүүлсний дагуу 2020.04.24-ны өдөр 20-р салбарын байрыг "Худалдах, худалдан авах гэрээ"-г байгуулж, төлбөрөө бүрэн төлсөн. Харин 26-р салбарын байрыг худалдан авахаас татгалзсан тул тогтоолын дагуу нээлттэй дуудлагын худалдаагаар хувьчлахаар нийтэд зарлаад байна.




Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020.05.15-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор Баруун сэлбэ үйлчилгээний төвийн "Ж" блокийн 1222 $м^2$ талбай бүхий байрыг Иргэний хуулийн 105 дугаар зүйлийн дагуу "Улаанбаатар радио" ХК-д тэргүүн ээлжинд санал болгон хувьчлахаар шийдвэрлэсэн. Тогтоолын дагуу "Улаанбаатар радио" ХХК-д 2020.05.26-ны өдрийн 3/1108 дугаар албан бичгээр мэдэгдэл хүргүүлсэн бөгөөд "Улаанбаатар радио" ХХК нь 2020.06.25–ны өдөр "Худалдах, худалдан авах гэрээ"-гээ байгуулж, төлбөр тооцоогоо бүрэн барагдуулсан тул Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020.07.08-ний өдрийн 26 дугаар тогтоолоор Өмчлөгчийн эрхийг шилжүүлсэн байна.




***Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах хуулийн этгээдийн талаар***

Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020.04.01-ний өдрийн 10 дугаар тогтоолоор "Чандмань Налайх" ОНӨААТҮГ-ын 8 хүний халуун ус бүхий үйлчилгээний төвийг хувьчлан авах этгээдийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтын хуваарийг баталж, хувьчлах үнийг 189,1 сая төгрөгөөр тогтоосон. Тогтоолын дагуу уралдаант шалгаруулалтыг нийтэд зарласан боловч оролцох хүсэлт ирээгүй.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/983 дугаар захирамжаар байгуулагдсан "Багахангайн мах боловсруулах үйлдвэр" ОНӨААТҮГ-ын тендерт оролцогчдоос ирүүлсэн саналыг үнэлж, дүнг гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг санал ирүүлсэн "Циркон геологи" ХХК-ийн тендерийг үнэлж, уралдаант шалгаруулалтад тэнцүүлсэн боловч Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020.07.30-ны өдрийн хурлаар дүнг хэлэлцээд тавигдсан шаардлагыг бүрэн хангаагүй байна хэмээн үзэн, уралдаант шалгаруулалтыг хүчингүйд тооцож, дахин зарлахаар шийдвэрлэн уралдаант шалгаруулалтын хуваарийг шинэчлэн баталсан болно. Хуваарийн дагуу 2020.08.07-ны өдөр уралдаант шалгарулалтыг нийтэд зарлан ба 2 компани оролцох хүсэлтээ ирүүлсэн боловч батлсан хуваарьт заасан хугацаанд тендерийн материалаа ирүүлээгүй тул уралдаант шалгаруулалт явагдаагүй.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/984 дүгээр захирамжаар байгуулагдсан "Үртсэн шахмал түлшний үйлдвэр" ОНӨААТҮГ-ын тендерт оролцогчдоос ирүүлсэн саналыг үнэлж, дүнг гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг оролцохоор материалаа ирүүлсэн "Эс эс макс" ХХК-ийн саналыг шаардлага хангаагүй гэж дүгнэн дүгнэлтээ Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020.07.30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн ба Нийслэлийн Өмч хувьчлах комиссоос уралдаант шалгаруулалтыг хүчингүйд тооцох тухай тогтоолыг баталсан. "Үртсэн шахмал түлшний үйлдвэр" ОНӨААТҮГ-ын талаар цаашид авах арга хэмжээний тухай санал боловсруулан ажиллаж байна.

### *3.2.8.Тээврийн хэрэслийн дуудлага худалдааны талаар:*

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/165, 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/821 дүгээр захирамжаар Нийслэлийн өмчит зарим байгууллагуудын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, техникийн комиссын актаар ашиглалтын шаардлага хангахгүй, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдсон тээврийн хэрэгслүүдийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдан нийслэлийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлээс хасуулах асуудлыг шийдвэрлүүлсэн. Үүнд:

- Сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэсэн нийт 2,338,082,403.6 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий, давхардсан тоогоор 36 байгууллагын 121 ширхэг тээврийн хэрэгслийг актлаж данс бүртгэлээс хасуулах асуудлыг боловсруулан газрын даргын тушаал гарган хүргүүлэв.
- Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу Тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлагын худалдааг 4 удаа зохион байгуулж нийт 700,907,980.0 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 34 ширхэг тээврийн хэрэгслийг худалдан 69,122,000.0 төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн.
- Нээлттэй дуудлагын худалдаагаар худалдагдсан тээврийн хэрэгслүүдийг худалдан авсан иргэдэд хүлээлгэн өгч, нийслэлийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлээс хасах тухай Газрын даргын тушаал гарган өмч эзэмшигч байгууллагуудад нь хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/1204 дүгээр захирамжаар Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын хөрөнгөнд бүртгэлтэй нийт 215,400,000 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 33 ширхэг тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай зарыг Өдрийн сонинд зарлуулсан боловч "Covid-19" цар тахалтай холбоотойгоор 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлагын худалдаа тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна.







### *3.3.1. Төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн талаар:*

2020 оны төсвөөр түрээсийн орлого 3,115 сая, ногдол ашгийн орлого 965 сая, өмч хувьчлал 73,360 сая, бусад орлого 160 сая төгрөгийг тус тус нийслэлийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан байна.

Өмч хувьчлалаас нийслэлийн төсөвт энэ онд 73,363.3 сая төгрөг төвлөрүүлэхээс 20,752.3 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөний биелэлт 28,3% байна.

1. Хан-Уул дүүргийн 12-р хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга – 41,7 сая төгрөг
2. "Монгол шуудан" ХК-ийн 20 дугаар салбарын байр – 76,6 сая төгрөг
3. "Монгол шуудан" ХК-ийн 23 дугаар салбарын 2 дугаар хэсэг – 254,6 сая төгрөг
4. Хуучнаар "Автобус-3" НӨҮГ-ын барилга байгууламж 20 020,0 сая төгрөг
5. Баянгол дүүргийн 10-р хорооны хуучин барилга 15,2 сая төгрөг
6. Баруун сэлбэ үйлчилгээний төвийн "Ж" блок – 308,3 сая төгрөг
7. Сүхбаатар дүүргийн 16-р хорооны ӨЭМТ-ийн хуучин барилга – 35,0 сая төгрөг

Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, зардлын хуваарийг сар, улирлаар гарган Санхүү төрийн сангийн хэлтсээр батлуулан мөрдөн, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 01-ний дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст мэдээ тайланг хүргүүлэн, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хүснэгтээр харуулбал:

| № | Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | (- илүү, +дутуу) |
|---|---|---|---|---|---|
| 1 | Түрээсийн орлого | 3,115,000.0 | 2,574,330.8 | 82.6% | 540,669.2 |
| 2 | Өмч хувьчлал | 73,360,000.0 | 20,751.309.6 | 28.3% | 52,608,690.4 |
| 3 | Ногдол ашиг | 965,000.0 | 497,045.7 | 51.5% | 467,954.3 |
| 4 | Акталсан хөрөнгө борлуулсны орлого | 160.000.0 | 147,839.1 | 92.4% | 12,160.9 |
| | ДҮН | 77,600,000.0 | 23,970,525.2 | 30.9% | 53,629,474.8 |

### *3.3.2. Төсвийн ил тод байдлын талаар:*

Монгол Улсын Төсвийн тухай хууль , Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор тус тус батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу мэдээллийг цаг тухай бүр мэдээлэн ажиллаж байна.

Хүснэгтээр харуулбал:

| № | Шилэн дансны мэдээллийн төрлийн нэр | Мэдээлэл оруулах давтамж | Мөнгөн дүн | Шийдвэр/гүйлгээний тоо |
|---|---|---|---|---|
| 1 | Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан | Бүтэн жил | https://info.shilendans.gov.mn PDF файлаар байршуулсан. | |
| 2 | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр | Тухай бүр | 1 468 249 382 | 30 |
| 3 | Санхүүгийн тайлан | Бүтэн жил | https://info.shilendans.gov.mn PDF файлаар байршуулсан. | |
| 4 | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт | Бүтэн жил | https://info.shilendans.gov.mn PDF файлаар байршуулсан. | |
| 6 | Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт | Улирал бүр | https://info.shilendans.gov.mn PDF файлаар байршуулсан. | |

| | | |
|---|---|---|
| ***Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ –***<br><br>**279 ш**<br>**47,276,373,949.54 төгрөг** | ***Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ –***<br><br>**238 ш**<br>**69,711,542,877.45 төгрөг** | **Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг**<br><br>**63**<br>**10,456,724,580.57 төгрөг** |

### *3.3.3. Түрээсийн гэрээ байгуулах, орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд:*

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоол, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны А/313 дугаар тушаалаар баталсан түрээсийн төлбөрийн жишиг үнийн дагуу түрээсийн төлбөрийг нэмэгдүүлэн гэрээ хийн ажиллаж байна. Иргэн, аж ахуйн нэгжтэй 2019 онд шууд болон дам түрээсийн 216 гэрээ байгуулж нийслэлийн төсөвт 515,548,272 төгрөгийг төвлөрүүлсэн бол 2020 онд нийт 171 гэрээ байгуулахаас хагас жилийн байдлаар 124 гэрээ байгуулан төлбөр 1,014,272,816 төгрөг болж нэмэгдсэн ба 2019 оны хагас жилийн гүйцэтгэлээс 219,524,300 төгрөгөөр орлого нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд түрээслэгч байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох журмыг үндэслэн нийт 124 түрээсийн гэрээг шинээр байгуулсан. Үүнд:

- *Шууд түрээсийн гэрээ – 18,* *Үнийн дүн – 242,101,300 төгрөг*
- *Дам түрээсийн гэрээ – 106,* *Үнийн дүн – 772,629,916 төгрөг*
- *Цуцлагдсан түрээсийн гэрээ-45,* *Үнийн дүн – 676,915,550 төгрөг*
- *Гэрээ байгуулах асуудал хүлээгдэж буй- 27,* *Үнийн дүн – 395,948,110 төгрөг.*




"Урт цагаан" үйлчилгээний төвд 30 түрээслэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага түрээсийн гэрээтэй ажиллаж нийслэлийн төсөвт 689,492,977 төгрөг төвлөрдөг байсан бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/216 дугаар

захирамжаар тус төвийн үйл ажиллагаа зогсоож түрээслэгчидтэй уулзалтыг зохион байгуулснаар ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах 12 иргэнтэй нийслэлийн төр захиргааны 4-р байранд түрээсийн гэрээг шинээр байгуулсан.

Соёлын төв өргөө нь 2019 онд нэгдсэн 1 шууд түрээсийн гэрээ байгуулан нийт 1,072,863,660 төгрөг төвлөрүүлсэн бол 2020 онд НИТХТ-ын 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ын дагуу НӨАУГ-ын балансад бүртгэлтэй барилга байгууламжийн талбайд нийт түрээслэгчидтэй шууд гэрээ байгуулахаар ажиллаж байна. Шууд гэрээ байгуулсан байгууллага, аж ахуйн нэгж:

- *Нийслэлийн Төрийн аудитын газар – 500 мкв, гэрээний дүн 77 сая төгрөг,*
- *"Гүүдвиар" ХХК – 51.2 мкв, гэрээний дүн 6.4 сая төгрөг*

Газрын даргын 2020 оны А/129 дүгээр тушаалаар "Үндэсний цэцэрлэгт хүрээлэн" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын байр, талбайн түрээсийн гэрээ дүгнэх, түрээслэгчийг сонгон шалгаруулах, "Худалдаа үйлчилгээ, соёл урлаг, биеийн тамир спортын үйл ажиллагааг зохион байгуулах Төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах журам" боловсруулах ажлын хэсэг байгуулагдан 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн ажиллаж байна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ын 6.1-д заасны дагуу түрээсийн гэрээний биелэлтийг "Үндэсний цэцэрлэгт хүрээлэн" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газартай харилцан дүгнэж ажлын хэсгийн дүгнэлтийг НЗДТГ-ын даргад танилцуулсан. НЗДТГ-ын даргын 2020.09.15-ны өдрийн А/108 дугаар тушаалаар тус үйлдвэрийн газрын байр, талбайн түрээсийн гэрээг зөрчсөн түрээслэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын гэрээг дуусгавар болгох үйл ажиллагаатай холбогдуулан шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт үүрэг болгосон.

Гэрээний хугацаа дуусгавар болсон 11, үйл ажиллагаа явуулаагүй 3 иргэн, аж ахуйн нэгж, түрээсийн журам болон гэрээний заалтуудыг зөрчсөн 2 иргэн, нийт 16 иргэн, аж ахуйн нэгжийн байр, талбай чөлөөлөх хамтарсан төлөвлөгөө боловсруулах, түрээсийн гэрээ цуцалсан иргэн, аж ахуйн нэгжтэй уулзалт хийх, түрээсийн төлбөрийн тооцоо дуусгах, байр талбай чөлөөлөх мэдэгдэл өгөх, байр, талбайг чөлөөлөхийг "Үндэсний цэцэрлэгт хүрээлэн" ОНӨТҮГ-ын дарга Ц.Энхбаяр хариуцан ажиллахаар ажлын хэсгийн гуравдугаар хурлаар шийдвэрлэсэн.

*<u>Нийслэлийн өмчийн барилга байгууламжид Түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хүрээнд:</u>*

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан " Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам"-ын хэрэгжилтийн хүрээнд нийслэлийн өмчит төсөвт байгууллагуудын сонгон шалгаруулалтын явуулах хүсэлтийг хүлээн авч судлан, урилгыг боловсруулж батлуулан байгууллагын цахим хуудас болон холбогдох байгууллагын байгууллагын сайтад байршуулан ажиллаж байна. Үүнд:

- *Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн 72м2 өвчтөний гал тогоо,*
- *Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн 23м2 цайны газар, буфет,*
- *Сүхбаатар дүүргийн "Өргөө" амаржих газрын өвчтөний хоол үйлдвэрлэл,*
- *Сонгинохайрхан дүүргийн 104-р сургууль - 71,2 м2,*
- *Сонгинохайрхан дүүргийн 82-р сургууль - 97,50м2,*

- *Сонгинохайрхан дүүргийн 153-р сургууль-407м2,*
- *Сонгинохайрхан дүүргийн Хөгжил цогцолбор 36-р сургууль - 114м2,*
- *Сонгинохайрхан дүүргийн Хөгжил цогцолбор 80-р сургууль - 114м2,*
- *Сонгинохайрхан дүүргийн "Өнөр" цогцолбор сургууль*
- *Баянзүрх дүүргийн 148-р сургууль - 423м2,*
- *Баянзүрх дүүргийн 133-р сургууль - 256,57м2,*
- *Баянзүрх дүүргийн 147-р сургууль-184м2 ,*
- *Баянзүрх дүүргийн "Шавь" цогцолбор сургууль - 66м2,*
- *Чингэлтэй дүүргийн 149-р сургууль - 82м2 /санал ирээгүй/*

### 3.3.4. Урт цагаан үйлчилгээний төвийн талаар:

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах нийслэлийн өмчийн 3 дугаар байр буюу Урт цагаан үйлчилгээний төв нь 1958 онд баригдаж ашиглалтад орсон нийт 7912,8 м2 бүхий талбайтай 12 блокоос бүрдсэн барилга бөгөөд 2009, 2011, 2014 оны мэргэжлийн байгууллагуудын удаа дараагийн дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсоор ирсэн. Иймд стандартын шаардлага хангахгүй тус төвийн үйл ажиллагааг зогсоох тухай Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/216 дугаар захирамж гарч 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс үйл ажиллагааг нь бүрэн зогсоосон болно.



Тус шийдвэр гарсантай холбогдуулан иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, захирамжийн хэрэгжилтийг хангах, цаашид хийж хэрэгжүүлэх талаар Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар нь холбогдох байгууллагатай хамтран дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд:

- 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр "Урт цагаан үйлчилгээний төв"-ийн үйл ажиллагааг зогсоох захирамжийг олон нийтэд танилцуулж, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга Ш.Үнэнбат, Орлогч дарга Д.Рэнцэнбямба, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар болон Нийслэлийн Онцгой байдлын газрын төлөөллийг оролцуулан хэвлэлийн бага хурлыг зохион байгуулан холбогдох мэдээллийг олон нийтэд хүргэсэн байна.





- "Урт цагаан үйлчилгээний төв"-д үйл ажиллагаа эрхлэгч 30 иргэн, аж ахуй нэгжид үйл ажиллагааг зогсоож байгаа талаар захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, мөн гэрээг цуцлах болсныг мэдэгдсэн.
- Нийслэл болон Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газартай ямар нэгэн эрх зүйн харилцаанд ороогүй, гэрээ байгуулаагүй, зөвшөөрөл авалгүйгээр үндсэн түрээслэгч гэгдэх 30 иргэн, аж ахуй нэгжээр дамжуулан түрээсэлдэг иргэдийг орхилгүй, тэдгээрийн санаа бодлыг сонсох, мэдээлэл судалгаа авах зорилгоор, батлагдсан хуваарийн дагуу 44 удаагийн уулзалтыг зохион байгуулж, 260 орчим иргэдийг хүлээн авч уулзаад байна. Мөн түрээслэгчдийн саналыг нэгтгэн холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтанд танилцуулан ажилласан байна. Тус төвийн 150 орчим түрээслэгчдийн дэлгэрэнгүй судалгааг гаргаад байна.






- 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр "Урт цагаан үйлчилгээний төв"-ийн 12 дугаар корпуст үйл ажиллагаа явуулдаг "Шинэ Монгол хуушуур" цайны газрын цэвэр усны болон дулааны шугам задар 800 гаран куб.метр ус газрын хөрсөнд алдагдсан бөгөөд 10 орчим сая төгрөгийн алдагдал үүсээд байна. Үүнтэй холбогдуулан 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдөр холбогдох байгууллагаас ус, дулааны инженер ирж засварлах боломжгүйг мэдэгдсэн.






- Тус төвийн үйл ажиллагааг зогсоож, тог цахилгааныг хязгаарласанд түрээслэгчид эсэргүүцэл үзүүлж жагсаал цуглаан зохион байгуулсан.









- "Урт цагаан үйлчилгээний төв"-ийн түрээслэгч нарыг ажлын байраар хангаж хамтарч ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичигт Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга Ш.Үнэнбат, "Урт цагаан худалдаа үйлчилгээний төвийн түрээслэгчдийн үйлдвэрчний эвлэл"-ийн хорооны дарга Х.Гантулга нар гарын үсэг зурлаа.



- 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс түрээслэгч нар нүүж эхлэн байр талбайгаа чөлөөлж өгсөн. Одоогийн байдлаар үндсэн 30 түрээслэгч аж ахуйн нэгжээс 5 нь /2000м2/ талбайг чөлөөлсөн байна.





- Нийслэлийн өмчийн 4 дүгээр байр буюу Улаанбаатар шилэн банкны 1 болон 2 давхрыг чөлөөлөн эхний ээлжинд 11 иргэн түрээслэгчтэй, шууд түрээсийн гэрээ байгуулан 1 давхарт 112м2 талбайд оёдол, бөс барааг шилжүүлэн оруулсан.









- Нийслэлийн Засаг даргын 2020.04.16-ны өдрийн "Уралдаан зохион байгуулах тухай" А/520 дугаар захирамжаар Урт цагаан үйлчилгээний төвийн барилгыг дахин төлөвлөх концевц зураг төсөл боловсруулах уралдааныг Хот байгуулалт хөгжлийн газартай хамтран 2020.04.20-05.11-ний өдрийн хороонд олон нийтийн дунд зарласан. Уг уралдаанд дотоод, гадаадын 28 баг бүтээлээ ирүүлсэн бөгөөд иргэдийн санал болон комиссын дүгнэлтээр шилдэг 3 зураг төсөл шалгаруулллаа.






















- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны "Урт цагаан үйлчилгээний төвийн 1 дүгээр корпусын барилга, байгууламжийг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай" 73 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны "Нийслэлийн өмчийн бүртгэлээс хөрөнгө хасах тухай" А/736 дугаар захирамж, Хот байгуулалт хөгжлийн газрын "Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ"/0006489 буулгалт-013/2020/-ний дагуу Урт цагаан үйлчилгээний төвийн 1 дүгээр корпусыг 2020 оны 07 дугаар сарын 22-ны өдөр буулгах ажлыг хийж гүйцэтгэсэн болно.









- Газрын даргын 2020 оны А/213 дугаар тушаалын дагуу 2020.05.20-ны өдрөөс 05.25-ны өдрийн хооронд Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байрны 2 давхрыг ахуйн үйлчилгээ, түрээсийн зориулалтаар тохижуулан "Дан шилэн хаалт"-аар тусгаарлах ажлыг 32.109.265.000 төгрөгөөр "Хаш Зэндмэнэ" ХХК-аар хийж гүйцэтгүүлэн 2020.05.26-ны хүлээн авч ажиллалаа.





- Урт цагаан үйлчилгээний төвтэй холбогдох мэдээ, мэдээллийг тухай бүр нь гэрээтэй ажилладаг 17 хэвлэл мэдээллийн байгууллагаар олон нийтэд хүргэж */давхардсан тоогоор 250 гаруй удаа/* ажилласан болно. Үүнд:
    - Хэвлэлийн бага хурлыг 4 удаа
    - Дүрстэй мэдээ-3
    - Нийтлэл -8
    - Санал асуулга -2
- 2020 оны 09 дүгээр сарын 15-17-ны өдрийн хооронд Нийслэлийн Өмчийн 4 дүгээр байрны 2 давхрын /гонх/ хэсгийг хаалтыг буулган байрны стандартат нийцүүлэн дахин засварласан.





- 2020 оны 11 сарын 7 –ны өдөр Нийслэлийн засаг захиргааны 4 дүгээр байранд "Урт цагаан үйлчилгээний төв"-ийн хаягыг байршуулсан.







- Тус төвд түрээсийн гэрээгээр үйл ажиллагаа явуулж байсан "Алаг даага" ХХК нарын 9 аж ахуй нэгж нь "Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх"-д нийслэлийн Засаг даргын А/216 дугаартай "Урт цагаан үйлчилгээний төвийн үйл ажиллагааг зогсоох тухай" захирамжийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг гаргасан бөгөөд энэ асуудал шүүхийн шатанд хянагдаж эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.

### *3.3.5. Захиалагчийн хяналт тавьж ажилласан ажлын талаар:*

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу 2020 онд нийт 13 захирамжаар 1, 962.7 сая төгрөгийн өртөг бүхий 24 төсөл хөтөлбөрт захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.

1. Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Эрх шилжүүлэх тухай" А/217 дугаар захирамжийн дагуу улсын төсвийн хөрөнгөөр санхүүжсэн "Баянгол Шинэ-Өргөө орон нутгийн өмчит тохижилт үйлчилгээний газрын тохижилт, үйлчилгээний машин, тоног төхөөрөмжийн шинэчлэлт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ -ийн нийлүүлэх БГД-ХААА/УТ-19-14 дугаар гэрээтэй Баянгол Шинэ-өргөө ОНӨААТҮГ-т хог тээврийн өөрөө буулгагч болон хог тээврийн шахагч автомашиныг байгууллагын даргын тушаалаар хөрөнгө хүлээн авах ажлын хэсэг томилон 2 удаа комисс ажиллуулж автомашинуудыг хүлээн авсан. Бичиг баримтын бүрдлийг ханган нийт 489,000,000 төгрөгийн санхүүжилтийг нийлүүлэгч Намдэмүн сервис ХХК-д олгуулах тухай 2020.01.29-ний өдрийн 2/172 дугаар албан бичгийг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлж, санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.
2. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/533 дугаар захирамжийн дагуу нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжих "Баянгол дүүрэгт хог тээврийн машин худалдан авах" БГД-ХААА/НТ-19-02 дугаартай гэрээнд захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. Байгууллагын даргын 2020.02.21-ний өдрийн А/54 дүгээр тушаалаар хөрөнгө хүлээн авах ажлын хэсэг байгуулан 2020.03.17-ны өдөр комисс ажиллуулан 195,000,000 төгрөгийн өртөг бүхий хог тээврийн өөрөө буулгагч автомашиныг хүлээн авч санхүүжилтийг олгуулсан.
3. Нийслэлийн Засаг даргын эрх шилжүүлэх тухай 2020 оны А/48 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх "Цагдаагийн хэлтсийн тоног төхөөрөмж /СХД, 9 дүгээр хороо/" төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба зохион байгуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас НХААГ/202001101 тоот гэрээг 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдөр "Бат тод" ХХК-тай байгуулсаны дагуу НӨАУГ-ын даргын 2020 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/278 дугаар тушаалаар "Цагдаагийн хэлтсийн тоног төхөөрөмж /СХД, 9 дүгээр хороо/" НХААГ/202001101 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдэж буй

хөрөнгийг хүлээн авах Ажлын хэсэг байгуулагдан, 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Ажлын хэсэг ажиллан, хөрөнгийг хүлээн авч, эзэмшигч байгуулага болох Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтэст актаар хүлээлгэн өгсөн.

4. Нийслэлийн Засаг даргын эрх шилжүүлэх тухай 2020 оны А/227 дугаар захирамжийн дагуу Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх "Хорооны Засаг даргын Тамгын газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 18, 19, 23, 27, 29, 38, 39 дүгээр хороо/" төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны алба зохион байгуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ЗГХЭГ/202002055 тоот гэрээг 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр "Төгсхурц консалтинг" ХХК-тай байгуулан манай газарт ирүүлсэний дагуу Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын даргын А/433 дугаар тушаалаар хөрөнгө хүлээн авах ажлын хэсэг байгуулж 2020 оны 08 дугаар сарын 10-ны өдөр, хөрөнгийг хүлээн авч, эзэмшигч байгууллага болох Сонгинохайрхан дүүргийн долоон хороонд актаар хүлээлгэн өгсөн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого,төлөвлөлтийн хэлтэст Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын 2020 оны 2/1609 тоот албан бичгээр санхүүжилтыг олгуулахаар төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьсан холбогдох баримт бичгийг хүргүүлсэн.
5. Нийслэлийн Засаг даргын эрх шилжүүлэх тухай 2020 оны А/228 дугаар захирамжийн дагуу Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх "Хорооны тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 1, 2, 20, 22, 33, 34, 35 дугаар хороо/" төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас НХААГ-20/0073 тоот гэрээг 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдөр "Ану гэгээн" ХХК-тай байгуулан, манай газарт ирүүлсэний дагуу НӨАУГ-ын даргын 2020 оны А/435 дугаар тушаалаар Хөрөнгө хүлээн авах ажлын хэсэг байгуулж хөрөнгийг хүлээн авч, эзэмшигч байгууллага болох Сонгинохайрхан дүүргийн долоон хороонд актаар хүлээлгэн өгсөн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст НӨАУГ-ын 2020 оны 2/1680 тоот албан бичгээр санхүүжилтыг олгуулахаар холбогдох баримт бичгийг хүргүүлсэн.
6. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/546 дугаар захирамжийн дагуу байгуулсан "Багахангай дүүрэгт Хот тохижилтын зориулалтаар дугуйт экскаватор худалдан авах" БХД-17/19 дугаартай гэрээнд захиалагчийн хяналт тавин ажиллаж,, хөрөнгийг хүлээн авах ажлыг зохион байгуулан, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн нийт 294,500,000 төгрөгийн санхүүжилтийг олгуулсан.
7. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/60 дугаар захирамжийн дагуу байгуулсан "Илч орд" ОНӨААТҮГ-т машин механизм нийлүүлэх гэрээнд захиалагчийн хяналт тавьж ажиллаж байна. *НӨАУГ-ын даргын 2020,05,13-ны өдрийн А/209 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг 2 тээврийн хэрэгслийг техникийн тодорхойлолтыг дагуу хүлээн авч, "Илч орд" ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгч, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн, санхүүжилт олгуулах албан тоотыг НЗДТГ-т хүргүүлэн* 278,0 сая төгрөгийн санхүүжилт олгуулсан.
8. Нийслэлийн Засаг даргын "Эрх шилжүүлэх тухай" 2019 оны А/288, 2020 оны А/86 дугаар захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ, "Нийслэлийн Төр захиргааны автобааз" УТҮГ-т хийгдэх төсөл арга хэмжээний 6 ажилд захиалагчийн хяналт тавьж, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны А/503, 2020 оны А/79, А/178 дугаар тушаалуудаар "Хөрөнгө хүлээн авах ажлын хэсэг"-ийг байгуулж нийт 1,0 тэрбум

төгрөгийн хөрөнгө хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох бичиг баримтуудыг боловсруулан, санхүүжилтийг шийдвэрлүүлж ажиллалаа.

9. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/877 дугаар захирамжийг үндэслэн "Би Си Ти" ХХК-тай байгуулсан "Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2020 онд худалдан авах тоног төхөөрөмж, Компьютер /4ш/, Принтер /2ш/" нийлүүлэх 21 дугаартай гэрээний дагуу хөрөнгө хүлээн авах Ажлын хэсэг байгуулж, 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр хөрөнгийг хүлээн авч, акт үйлдэн, тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэлийг гарган, гэрээ дүгнэсэн проткол үйлдэн, НЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст НӨАУГ-ын 2020 оны 2/1621 тоот албан бичгээр ажлын санхүүжилт болох 9,9 сая төгрөгийг олгох тухай хүсэлт явуулсан.
10. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/437 дугаар захирамжийн дагуу байгуулсан Өөрөө буулгагч ачааны машин 2ш /20-24 тн/, усны машин сордог 2ш /10тн/, халуун уураар үлээгч /шугам хоолойн хөлдөлт гэсгээх тусгай зориулалтын тоног төхөөрөмж/ Дугаар № НХААГ-19/090-1/1 нийлүүлэх гэрээнд захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. Бараа нийлүүлэх эцсийн хугацаа 2020 оны 6 дүгээр сарын 1-ний өдөр дуусгавар болсон боловч бараа нийлүүлэгдээгүй тул НЗДТГ-аас гэрээг цуцалсан.
11. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр 05/5408 тоот албан бичгээр Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаас Нийслэлийн Засаг даргад худалдан авах ажиллагааны эрх шилжиж ирсэн "Хорооны тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 1, 2, 20, 22, 33, 34, 35 дугаар хороо/" төсөл, арга хэмжээ хасагдсан тул санхүүжүүлэх боломжгүй байна. Үүнтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас тоног төхөөрөмжийг комисс томилогдож хүлээн авсан тул дээрх төсөл, арга хэмжээг Монгол улсын 2021 оны Төсвийн тухай хуульд тусгаж, санхүүжүүлэх тухай албан бичгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад хүргүүлсэн байна.
12. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/428 дугаар Эрх шилжүүлэх тухай захирамжийн дагуу "Хот байгуулалталтын мэдээллийн сангийн тоног төхөөрөмж нийлүүлэх" ажилд захиалагчийн хяналт тавьж ажиллаа. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны А/280 дугаар тушаалаар Хөрөнгө хүлээн авах ажлын хэсэг байгуулж тоног төхөөрөмжүүдийг 2020.06.17 болон 2020.08.14-ний өдрүүдэд актаар хүлээн авсан. Гүйцэтгэгч Саммит компьютер технологи ХХК-ийн санхүүжилтийг олгохоор холбогдох баримт бичгийг бүрдүүлж НЗДТГ-т 2020 оны 2/1589 тоот албан бичгээр хүргүүлсэн.

### *3.3.6. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн талаар:*

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар нь 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/326, 2020 оны 04 дүгээр сарын 23-ны А/177 дугаар тушаалаар зохион байгуулалтын өөрчлөлтүүдийг боловсруулан батлуулж, байгууллага Газрын дарга-1, Орлогч дарга- 2, Нэгжийн дарга- 4, ахлах мэргэжилтэн- 5, төрийн захиргааны албан тушаалын ангилалд- 38 /үүнээс: албан хаагч түр орлон гүйцэтгэгч- 3, сул орон тоо- 2/, төрийн үйлчилгээний албан тушаалын ангилалд- 27/үүнээс: сул орон тоо-1/, гэрээт ажилтан– 2 гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

- Төрийн албаны тухай хуулийн 54, 55 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 37 дугаар тогтоолын дагуу байгууллагын гүйцэтгэлийн боловсруулж, газрын даргаар батлууллаа. Мөн Төсвийн шууд захирагчаар батлуулах 4 нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, нэгжийн дарга нараар батлуулах 37 төрийн жинхэнэ албан хаагчдын

гүйцэтгэлийн төлөвлөгөө, газрын даргатай байгуулах 27 төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг хагас, бүтэн жилээр үнэлэх, дүгнэх явцад хяналт тавин ажиллалаа.

- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02, 03 дугаар тогтоолын дагуу Төрийн захиргааны 37 алтан хаагчийн 24 ажлын байрны Албан тушаалын тодорхойлолтыг ТАЗ, НТАЗСЗ-тэй хамтран боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 111 дүгээр тогтоолоор зөвшөөрөл аван, газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/204 дүгээр тушаалаар, төрийн үйлчилгээний албан хаагчдын 18 ажлын байрны албан тушаалын тодорхойлолтыг газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 05 дугаар сарын 25-ны А/230 дугаар тушаалаар батлууллаа.
- Төрийн албаны зөвлөлийн "Хүний нөөцийн удирдлагын систем" нь цалин хөлсний төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтыг сайжруулах, төсвийн байгууллагуудын төсөв бэлтгэх ажлыг автоматжуулах, албан хаагчдын цалин хөлстэй холбоотой бүх төрлийн мэдээлэл автоматаар илгээгдэх зэрэг зорилгоор шинэчлэгдэн баяжуулагдаж, улсын хэмжээнд нэгдсэн мэдээллийн сантай болох болсонтой холбогдуулан Төрийн албаны цалингийн нэгдсэн систем/ТАЦНС/-д албан хаагчдын мэдээллийг тогтмол шинэчлэн оруулж байна.

Ажлын үр бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд ажлын цаг ашиглалтад хяналт тавьж, эмнэлэгийн чөлөөтэй - 13 /листээр/, захиргааны чөлөөтэй – 34, газрын даргын тушаалаар- 3 албан хаагчийн чөлөө олгох бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж, сар бүрийн эцэст албан хаагчдын хоцролт, таслалтын мэдээг минутаар гарган орлогч дарга, хэлтсийн дарга нарт НЗДТГ, НТАЗСЗ, холбогдох бусад байгууллагуудад дараах мэдээ, судалгаануудыг гаргаж хүргүүллээ. Үүнд:

- ✓ Удирдах албан тушаалтнуудын судалгаа
- ✓ Ёс зүйн зөрчлийн мэдээ
- ✓ Худалдан авах ажиллагааны А3 сертификаттай албан хаагчдын судалгаа
- ✓ Өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах албан хаагчдын судалгаа
- ✓ 0-6, 0-12 насны хүүхэдтэй эхчүүдийн судалгаа
- ✓ 50-аас дээш настай албан хаагчдын судалгаа
- ✓ Албан хаагчдын орон сууцны судалгаа
- ✓ Хуульчдын сонгон шалгаруулалтад орсон албан хаагчдын судалгаа
- ✓ Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангаан ажилласан талаарх судалгаа
- ✓ Бүтэц орон тооны судалгаа
- ✓ Албан тушаалын ангиллын судалгаа
- ✓ Албан хаагчдын хаягийн судалгаа
- ✓ Төрийн албан хаагчийн нөөцийн судалгаа
- ✓ Сул орон тооны судалгаа
- ✓ Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах албан тушаалтнуудын судалгаа
- ✓ "Хууль эрх зүй", "Төрийн албан хаагчийн ёс зүй", "Стандарт, чанарын удирдлага" сэдэвт сургалтад хамрагдах албан хаагчдын судалгаа.

*<u>Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2017-2020 оны "Хүний нөөцийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:</u>*

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газраас "2020 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө", "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах

2020 оны төлөвлөгөө", 2020 онд зохион байгуулах "Мэдээллийн цаг"-ийн хуваарь зэргийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

**Сургалтын төлөвлөгөөний дагуу хамрагдсан сургалтууд**

- Худалдан авах ажиллагааны эрх А3 сертификат олгох сургалтад 5 албан хаагч хамрагдаж 400 000 төгрөгийг зардал гарсан.
- Авилгатай Тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" болон "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт сургалтад нийт албан хаагчид хамрагдсан.
- "Нэг хот-Нэг стандарт" зорилтот жилийн хүрээнд зохион байгуулагдсан 2 удаагийн сургалтад хэлтсийн дарга нар хамрагдсан.
- Цалин хөлсний төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтыг сайжруулах, төсвийн байгууллагуудын төсөв бэлтгэх ажлыг автоматжуулах зорилгоор улсын хэмжээнд нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх "Хүний нөөцийн удирдлагын систем" ,"Төрийн албаны цалингийн нэгдсэн систем"-ийн талаарх 3 өдрийн онлайн сургалтад хүний нөөц, ахлах мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан хамрагдсан.
- Авилгатай Тэмцэх газар, Азийн сангаас зохион байгуулсан "Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалт, эрх бүхий албан тушаалтны анхаарах асуудал", Авлигын талаарх олон нийтийн ойлголт, судалгаа, дүн шинжилгээ сэдэвт сургалтад хүний нөөц, ахлах мэргэжилтэн
- Төрийн байгууллагуудын "Ёс зүйн зөвлөлийн нэгдсэн зөвлөгөөн-2020" -д 2020.09.24-ний өдөр хүний нөөц, ахлах мэргэжилтэн хамрагдсан.
- Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Чадахуйн зарчим", "Хүний нөөцийн аудит" сэдэвт сургалтад 2020.09.24-ний өдөр хүний нөөц, ахлах мэргэжиилтэн хамрагдсан
- "Гэр бүлийн хүчирхийлэл, өсвөр насны хүүхдийн хүмүүжил" сэдвээр Дэлхийн Монгол угсаатны эх үрсийн нийгэмлэгийн тэргүүн Ж.Нямаа урин сургалт-ярилцлага
- Нийслэлийн Архивын газраас ахлах мэргэжилтэн Ж.Бямбаа, сургалт хариуцсан мэргэжилтэн Б.Мядаг нар 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдөр "Тоон гарын үсгээр албан бичиг солилцох тухай" сэдэвт сургалт.






Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын дагуу 10 төрийн жинхэнэ албан хаагчид албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг Нийслэлийн Төрийн Албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлснээс Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр

сарын 01-ний А/452 дугаар захирамжаар 5 албан хаагчид төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгуулсан.

- "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын дагуу 5 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай газрын даргын 2020.05.20-ны өдрийн А/216 дугаар тушаалаар олгосон.
- Холбогдох хууль болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу ар гэрт нь гачигдал тохиолдсон 3 албан хаагчид 900 000 төгрөгийн тэтгэмжийг олгосон.

***Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах талаар:***

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст байгууллагын төрийн захиргаа, төрийн үйлчилгээний албан тушаалтнуудаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг хүргүүлж, хуулийн үйлчлэлд хамаарах ТЗ-6-аас дээш ангиллын албан хаагчдаас 2019 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг/2019/-ийг баталгааны хуудсаар хүлээн авлаа.
- Ажлын хэсэгт орсон 5 гишүүнээс "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг авсан тухай мэдээллийг,
- Хувийн ашиг сонирхлын урьдчилсэн мэдүүлгийг 3 албан хаагчаас авч холбогдох материалын хамт Авлигатай Тэмцэх газарт хүргүүлэн хянуулж, мэдээллийг,
- Их хэмжээний өөрчлөлтийн мэдүүлэг/2019+/-ийг 1 албан хаагчаас баталгааны хуудсаар авч, холбогдох мэдээллийг,
- Дэвшүүлэн буюу шинээр томилогдсон 2 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг /2019+/-ийг тус тус авч цахим /www.meduuleg.iaac.mn/-д баталгаажуулан тайлагналаа.

### *3.3.7. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлсэн талаар*

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн 2020 оны ажлын төлөвлөгөө болон байгууллагын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг 2016-2019 оны байдалтай харьцуулан дүн шинжилгээ хийж байгууллагын удирдлагаар хэлэлцсэн. Үүнд:

- Төсвийн орлогын бүрдүүлэлт 3,494,357.90 мянган төгрөг үүнээс ногдол ашиг 955,976.6 мянга, түрээсийн орлого 2,074,865,4 мянган, актлагдсан хөрөнгийн орлого 160,420.9 мянга, өмч хувьчлалын орлого 0 төгрөг байна. Орлогын өсөлт, бууралтыг харуулбал:

  - *2016:2019 өссөн 756,294.10 21.6%*
  - *2017:2019 буурсан (4,556,897.20) -130.4%*
  - *2018:2019 буурсан (8,141,078.60) -233.0%*

  *Өмч хувьчлалын орлогын төлөвлөгөө 2019 онд 50,220,000.0 мянган төгрөг, гүйцэтгэл 314,974.0 мянган төгрөг, биелэлт 0.6% -тай байгаа нь орлого буурахад нөлөөлсөн.*




- Улс нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, бусад төрлийн эх үүсвэрээр бий болсон 39,311.7 мянга төгрөгийн барилга байгууламж, 12,719.8 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл бүртгэсэн байна. Өсөлт, бууралтыг харуулбал:
    - *2016:2019 буурсан (84,749,481.4) -162.9%*
    - *2017:2019 буурсан (36,144,382.8) -69.5%*
    - *2018:2019 өссөн 19,453,124.3 37.4%*

- Нийслэлийн өмчид хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу 3,410.7 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 1,872.0 мянган төгрөгийн барилга байгууламж балансаас балансад шилжүүлсэн байна. Өсөлт, бууралтыг харуулбал:
    - *2016:2019 буурсан (171,847,104.9) -3253.0%*
    - *2017:2019 буурсан (4,940,451.0) -93.5%*
    - *2018:2019 өссөн 4,651,322.6 88.0%*







- ЭБХХХК-ын хурлаар 2,496,190.5 мянган төгрөгийн хөрөнгө шинээр худалдан авах, 1,871,394.2 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, 10,786,948.6 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасах, 5,245,649.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэх шийдвэр гаргасан байна. Хөрөнгийн асуудал шийдвэрлэсэн байдал оноор харуулбал:

    - *2016 он – нийт 88,813,578.1 мян.төг,*
    - *2017 он - нийт 20,664,994.0 мян.төг*
    - *2018 он – нийт 28,366,056.6 мян.төг,*
    - *2019 он – нийт 20,400,182.8 мян.төг*




| | Хөрөнгө худалдан авах | Хөрөнгө бүртгэх | Балансаас балансад шилжүүлэх | Хөрөнгө данснаас хасах |
|---|---|---|---|---|
| 2016 он | 2,526,791.1 | 74,200,977.3 | 1,489,155.5 | 10,596,654.2 |
| 2017 он | 2,475,475.1 | 6,425,695.3 | 1,647,835.8 | 10,115,988.7 |
| 2018 он | 1,517,004.8 | 7,206,373.5 | 7,417,406.0 | 12,225,272.3 |
| 2019 он | 2,496,190.5 | 5,245,649.5 | 1,871,394.2 | 10,786,948.6 |

- Нийслэлийн өмчит төсөвт 704 байгууллагуудын “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ” дүгнэж “Бүрэн хангалттай” 548, “Хангалттай” 141, “Ажил сайжруулах” 15, “Хангалтгүй” 0, дүгнэгдээгүй 14 байгууллага байна. Дүгнэлтийг жил бүрээр харуулбал:
  - *2016 онд 635 байгууллага, дундаж оноо 83*
  - *2017 онд 632 байгууллага, дундаж оноо 78*
  - *2018 онд 645 байгууллага, дундаж оноо 80*
  - *2019 онд 704 байгууллага, дундаж оноо 77.8*



## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:

## БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

### *4.1. Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг хөнгөн шуурхай болгох стратегийн зорилтын хүрээнд:*

Нийслэлийн Өмчийн харилцааны талаарх мэдээ мэдээллийг түгээх, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээ мэдээлэл хүргэх, үйл ажиллагааг зохицуулах зорилгын хүрээнд МУ-ын хууль Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоол "Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам", Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоол "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт"-ийг байгууллагын цахим хуудасны үйл ажиллагаанд мөрдлөг болгон үндсэн үйл ажиллагаатай холбоотой болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулагдаж буй ажлуудын талаарх мэдээллийг байршуулан ажиллаж байна.

Байгууллагын веб-сайтад олон нийтэд нээлттэй ил тодоор дараах мэдээллүүдийг байршуулсан.

*Үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангах ажлын хүрээнд:*

- Байгууллагын дүрэм
- Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм
- Хөдөлмөрийн дотоод журам
- Дагаж мөрдөж буй дүрэм журмууд
- Үйл ажиллагааны тайлан / I улирал /
- Төрийн үйлчилгээ өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтний мэдээлэл
- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ / I улирал /
- Албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ / I улирал/
- Албан хаагчидтай холбогдох утасны жагсаалт албан и-мэйл
- Үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарсан газрын даргын 239 тушаал
- Үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарсан НИТХТ-ийн 23 тогтоол

Хүний нөөцийн ил тод байдлын хүрээнд:

- Байгууллагын дүрэм
- Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм
- Хөдөлмөрийн дотоод журам
- Газрын даргын тушаалаар батлагдсан дотооддоо дагаж мөрдөж буй дүрэм журмууд
- Үйл ажиллагааны тайлан / 2020 оны эхний хагас жил /
- Төрийн үйлчилгээ өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтний мэдээлэл
- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ / 2020 оны эхний хагас жил /
- Албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ / 2020 оны эхний хагас жил/
- Албан хаагчидтай холбогдох утасны жагсаалт албан и-мэйл хаягийг тогтмол шинэчилдэг
- Үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарсан газрын даргын 239 тушаал
- Үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарсан НИТХТ-ийн 23 тогтоол

*Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээллүүдийг тухай бүр шинэчлэн байршуулж байна.*

- ❖ Нийслэлийн ЕБ-ын лаборатори 142 дугаар сургуулийн "Үдийн цай" хөтөлбөрийг хэрэгжүүлэгч цайны газрын түрээслэгчийг сонгон шалгаруулах урилга
- ❖ Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв хүүхдийн эмнэлгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг түрээслүүлэх сонгон шалгаруулалтын зар
- ❖ Тээврийн хэрэгслийн дуудлага худалдааны зар болон зохион байгуулсан талаарх мэдээ
- ❖ Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журам", "Нийслэлийн өмчийн байр, талбайг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдуулан санал авах тухай
- ❖ Журам, гэрээний төсөл батлуулсан талаар

<u>Төсөв санхүүгийн ил тод байдлын хүрээнд:</u>

- ❖ Нийслэлийн ЕБ-ын лаборатори 142 дугаар сургуулийн "Үдийн цай" хөтөлбөрийг хэрэгжүүлэгч цайны газрын түрээслэгчийг сонгон шалгаруулах урилга
- ❖ Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв хүүхдийн эмнэлгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг түрээслүүлэх сонгон шалгаруулалтын зар
- ❖ 2020 оны төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ/сар бүрээр/
- ❖ Санхүүгийн тайлан /2019 оны тайлан/
- ❖ Аудитын дүгнэлт
- ❖ Дотоод аудитын хяналт шалгалтын материал

Байгууллагын үйлчилгээний талаарх санал хүсэлтийн хуудсыг боловсруулан саналыг хайрцгаар авч байна.


СЭТГЭЛ ХАНАМЖИЙН САНАЛ АСУУЛГЫН ХУУДАС 1

### *4.2. Хяналт, шинжилгээ үнэлгээний ажлын талаар:*

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 335 дугаар захирамжаар баталсан журмын хавсралтад заасны дагуу байгууллагын 2020 оны "Хяналт шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө" боловсруулж удирдлагад танилцуулсан. Үүнд:

- Бодлогын баримт бичгийн биелэлтийг хангах 4 тайлан, мэдээ
- Тогтоол шийдвэр, удирдлагаас гарсан шийдвэрийг хангах 6 тайлан, мэдээ
- Байгууллагын үйл ажиллагааны мэдээ 4 тайлан, мэдээ

| Тайлан мэдээний төрөл | Тайлан, мэдээний нэр |
|---|---|
| *1.0 Бодлогын баримт бичгийн биелэлтийг хангах* | 1.1 Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх |
| | 1.3 Нийслэлийн эдийн засаг нийгмийг тухайн жилд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх |
| | 1.4 НЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх |
| *2.0 Тогтоол шийдвэр удирдлагаас гаргасан шийдвэрийг хангах* | 2.1 УИХ-ын тогтоол, УИХ-ын БХ-ны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн шийдвэр, ЗГ-ын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх |
| | 2.2 НИТХ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх |
| | 2.3 НЗД-ын захирамжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх |
| *3.0 Байгууллагын үйл ажиллагааны мэдээ* | 3.1 Байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх |
| | 3.2 Байгууллагын хүний нөөцийн бодлогын хэрэгжилттэй холбогдолтой мэдээ, тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх |
| | 3.3 Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг зохион байгуулсан ажлын тайлангийн дүн шинжилгээ |
| | 3.4 Албан бичиг шийдвэрлэлтийг зохион байгуулсан ажлын тайлан |

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2, 6.3-т заасны дагуу байгууллагын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн Илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан. Үүнд:

- *Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2019.12.05-ны өдрийн 10/5979 тоот албан бичгийн хавсралтаар ирүүлсэн 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг тооцож, биелэлтийн мэдээ гаргах тогтоол шийдвэрийн заалтын жагсаалт, мэдээ ирүүлэх хүснэгтийн загварын дагуу гаргасан 55 тогтоол шийдвэр,*
- *Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2020.05.21-ний өдрийн 10/2643 дугаар албан бичгийн хавсралтаар ирүүлсэн Засгийн газрын тогтоол 3, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол 19,*
- *Нийслэлийн Засаг даргын эрх шилжүүлэх тухай 170, захиалагчийн хяналт тавих 25, худалдан авах ажиллагаа зохион байгуулах 1, үндсэн үйл ажиллагаатай холбоотой 89, нийт 285 захирамж,*
- *Байгууллагын 2019 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан үйл ажиллагаа"-ны 6 зорилтын 11, "Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны 49 нийт 60 үйл ажиллагаа,*
- *Байгууллагын 2020 оны эхний хагас жил, гуравдугаар улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ"-ний 4 зорилтын 6 арга хэмжээ, "Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ"-ний 3 зорилтын 10 арга хэмжээ, "Хуулиар олгосон чиг үүргийг*

*хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ"-ний 20 зорилтын 32 арга хэмжээ, нийт 27 зорилтын 48 арга хэмжээ,*

- *ERP програмаар байгууллагад 2019 онд ирсэн 78 өргөдөл, гомдол, 2020 оны хоёрдугаар улирлын байдлаар иргэд, аж ахуйн нэгжээс ирсэн нийт 84 өргөдөл, гомдол, гуравдугаар улирлын байдлаар иргэд, аж ахуйн нэгжээс ирсэн нийт 84 өргөдөл, гомдлын хандалт,*
- *ERP программаар байгууллагад 2019 онд ирсэн нийт 4,083 албан бичиг*

*Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн талаар:*

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2019.05.21-ний өдрийн 10/2643 тоот албан бичгийн хавсралтад ирүүлсэн 2020 оны эхний хагас жилийн байдлаар тооцож, биелэлтийн мэдээ гаргах тогтоол шийдвэрийн заалтын жагсаалтын дагуу 32 хэрэгжилтийн нэгтгэлд дүн шинжилгээ хийсэн.

*Тогтоол шийдвэрийн дундаж үнэлгээг харуулбал:*

| | |
|---|---|
| *✓ Засгийн газрын 3 тогтоолын 11 арга хэмжээнээс:* | |
| *- 1 тогтоолын 9 арга хэмжээ* | *92.22%* |
| *- 2 тогтоолын 2 арга хэмжээ* | *хэрэгжилтийн хугацаа тооцох болоогүй* |
| *✓ Засгийн газрын хуралдааны 2 тэмдэглэлийн 2 арга хэмжээ, үүнээс 2018 оны №25* | *69.75% тасарсан* |
| *✓ НИТХТ-ын 19 тогтоолын 19 арга хэмжээнээс:* | |
| *- 18 тогтоолын 18 арга хэмжээ* | *90.00%* |
| *- 1 тогтоолын 1 арга хэмжээ* | *хэрэгжилтийн хугацаа тооцох болоогүй* |
| *үүнээс 2019 оны №46, №47, №48* | *удааширсан* |

Захирамжийн хэрэгжилтийн талаар

Өнгөрсөн 2019 онд байгууллагад НЗД-ын эрх шилжүүлэх тухай 170, захиалагчийн хяналт тавих 25, худалдан авах ажиллагаа зохион байгуулах 1, үндсэн үйл ажиллагаатай холбоотой 89, нийт 285 захирамж ирж биелэлт 98.4% хувьтай байна.

Нийслэлийн Засаг даргын эрх шилжүүлэх 170 захирамжийн хэрэгжилт:

- *Бүрэн хэрэгжсэн* — *3 – 100%*
- *Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй* — *167*

Нийслэлийн Засаг даргын захиалагчийн хяналт тавих 25 захирамжийн хэрэгжилт:

- *Бүрэн хэрэгжсэн /90%-100%/* — *20 – 99.5%*
- *Хэрэгжих шатанд /50%-89%/* — *4 – 62.5%*
- *Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй* — *1*

Нийслэлийн Засаг даргын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 89 захирамжийн хэрэгжилт:

- *Бүрэн хэрэгжсэн /90%-100%/* — *84 – 99.7%*
- *Хэрэгжих шатанд /50%-89%/* — *1 – 70%*
- *Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй* — *4*

Хагас жилийн байдлаар Нийслэлийн Засаг даргын эрх шилжүүлэх тухай 11, үндсэн үйл ажиллагаатай холбоотой 40, нийт 285 захирамжийг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийслэлийн Засаг даргын эрх шилжүүлэх 11 захирамжаас "Бүрэн хэрэгжсэн" 2 буюу 97.5%, "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" буюу гадаад хүчин зүйлээс шалтгаалан үнэлэх боломжгүй 9 захирамж байна. Мөн үндсэн үйл ажиллагаатай холбоотой

40 захирамжаас "Бүрэн хэрэгжсэн" 39 буюу 100%, "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" 1 захирамж байна.

Эрх шилжүүлсэн 11 захирамж



Үндсэн үйл ажиллагааны 40 захирамж




"Бүрэн хэрэгжсэн" үнэлгээтэй захирамжийн хэрэгжилтийг хэлтэс бүрээр харуулбал:

Эрх шилжүүлсэн 2 захирамж




Үндсэн үйл ажиллагааны 39 захирамжаас




### *4.3. Хяналт шалгалтын ажлын талаар:*

Хяналт шалгалтын ажлын 2020 оны төлөвлөгөөний 12 ажлын төслийг боловсруулан Удирдлагын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Үүний дагуу дараах ажлын хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

- *Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Ахмадын хорооны үйл ажиллагаатай асуудлаар холбогдох ажилтнуудтай уулзан, хөрөнгийн тооллогын бүртгэлтэй тулгалт хийн өмч хөрөнгийн байдлыг газар дээр нь шалгасан. Шалгалтаар хорооны барилгын 1-р давхарт Ахмадын хороо, 2-р давхарт СБД-н 14-р хорооны "Өнөр өрх" өрхийн эрүүл мэндийн төв үйл ажиллагаа явуулдаг байна.*
- *Нийслэлийн Өргөө амаржих газрын нийслэлийн өмчийн илүүдэлтэй байр талбайг түрээслэн үйл ажиллагаа эрхэлж буй 8 иргэн, аж ахуйн нэгжийн түрээсийн гэрээний биелэлт, төлбөр тооцоонд 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдөр шалгалт хийсэн. Түрээслэгчид гэрээнд заасан зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2019 оны түрээсийн төлбөрийн үлдэгдэлтэй 1, 2020 оны түрээсийн гэрээ байгуулаагүй 2 аж ахуйн нэгж байна. Холбогдох зөрчлийн арилга талаар түрээслэгчид мэдэгдсэн.*
- *Газрын даргын 2020 оны А/129 дүгээр тушаалаар "Үндэсний цэцэрлэгт хүрээлэн" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын байр, талбайн түрээсийн гэрээ дүгнэхтэй холбогдуулан хүрээлэнгийн түрээсийн байр талбайн хэмжилт хийн, түрээсийн тооцоо судалгаа гаргасан. Мөн Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, прокурор, цагдаагийн байгууллагаас 2018, 2019 онуудад хийсэн шалгалт, илэрсэн зөрчлийн талаарх мэдээллүүдийг нэгтгэн удирдлагад танилцуулсан.*
- *Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын балансад бүртгэлтэй нүхэн гарцын түрээсийн талбайн хэмжилтийг хийн баримтаар баталгаажуулсан.*
- *Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн өвчтөний цайны газрыг ажиллуулж буй "Хатан цох" ХХК, Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын цайны газрыг ажиллуулж буй "Мардай гурван эрдэнэ" ХХК нь түрээсийн гэрээний үүргээ биелүүлээгүй буюу түрээсийн*

*төлбөрөө төлөөгүй тул 2020 оны 05 дугаар сарын 26-ны өдөр газар дээр очиж танилцан, 2020 оны 06-р сарын 01-ний өдөр нийслэлийн өмчийн байр талбайг чөлөөлөхийг мэдэгдэн албан бичиг өгсөн.*

- *Соёлын Төв өргөөний офиссийн хэсгийн барилгын дотор схем зургийн дагуу 2020.05.19-ний өдөр байр талбайн хэмжилт хийж эзэмшилт ашиглалтын байдалтай танилцсан. Нэгдүгээр давхрын 7 өрөө бүхий 205,4 м2 талбайгаас нотариат, зураачин, Бага дарга нарын холбоо, Соёлын үндэсний төв 145 м2 гэрээгээр эзэмшдэг, 10 м2 талбай ашиглалтгүй, ажилчид болон цахилгааны шитний зориулалтаар 50,4 м2 талбай эзэмшиж байна. Хоёрдугаар давхарт 8 өрөө бүхий 252 м2 талбайг Соёлын үндэсний төв эзэмшиж ашиглаж байна. Эзэмшилт ашиглалтын судалгаа болон байр, талбайн схем зургийг удирдлагад танилцуулсан.*
- *Нийт 28 иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулсан түрээсийн гэрээний биелэлт, төлбөр тооцоонд хийх төлөвлөгөөний дагуу Өргөө амаржих газрын 8 түрээсийг газар дээр шалган танилцуулсан.*
- *Газрын даргын 2020 оны А/524 дүгээр "Ажлын хэсэг байгуулж, удирдамж батлах тухай" тушаалаар "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний биелэлтийг дүгнэж, үнэлэлт, дүгнэлт өгөх ажлын хүрээнд Хан-уул, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, хадгалалт, илүүдэлтэй байр талбайд ашиглалтад шалгалт хийсэн бөгөөд цар тахлын нийтийн хорио цээр тогтоосны улмаас зогссон болно.*

## *4.4. Хууль шүүхийн байгууллагад төлөөлөх ажлын талаар:*

Тайлант хугацаанд нийт 25 хэрэг шүүхээр хянагдаж байгаагаас Анхан шатны шүүхэд 20 хэрэг, Давж заалдах шатны шүүхэд 2, Хяналтын шатанд 3 хэрэг хянагдаж байна. */Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаар оруулав./*

1. Анхан шатны шүүхэд хянагдаж байгаа хэргийн мэдээ
/2020.12.10-ны өдрийн байдлаар/

| Д/д | Нэхэмжлэгч | Хариуцагч | Шүүх | Шүүгч | Шүүхэд нэхэмжлэл гаргасан огноо | Нэхэмжлэлийн утга | Итгэмжлэгдсэн төлөөлөгч | Шийдвэр, тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | " Буяннэмэх интер" ХХК | НӨАУГ | Захиргааны шүүх | Мөнхтулга | 2019.06.28 | 332 000 000 төгрөгийн үнэ бүхий бага оврын цахилгаан төхөөремжийн төлбөрийн тухай | М.Энхболд | Шинжээчийн дүгнэлт гаргуулахаар түдгэлзүүлсэн байгаа |
| 2 | " Наранбулаг" ХХК, " Бадрал" ХХК | НИТХ НӨХК Гуравдагч этгээд: " Улаанбаатар радио" ХХК | Захиргааны шүүх | Батцэрэн | 2020.05.29 | - НИТХ-ын 2020.4.30-ны өдрийн 60-р тогтоол, НӨХК-ын 19-р тогтоолыг тус тус хүчингүй болгох.<br>- НИТХ-ын 2020.04.30-ны өдрийн 60 дугаар тогтоолоор "УБ радио" ХХК-ийг санал болгож хувьчлахаар шийдвэрлэсэн.<br>- НӨХК-ын 2020.05.15-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор 1 590 000 000 төгрөгөөр "УБ радио" ХХК-ийг хувьчлахаар тэргүүн ээлжинд санал болгож, шийдвэрлэсэн. | Д.Иттэл | 2020.07.31-ний өдрийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар 60, 19 дүгээр тогтоолыг түдгэлзүүлсэн байгаа.<br>2020.12.07-ны шүүх хуралдаан дээр "УБ радио" ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг нэмэгдүүлсэн. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | " Шинэ центр" ХХК | НЗД Гуравдагч этгээд: НӨАУГ | Захиргааны шүүх | Мөнхтулга | 2020.04.17 | Газрын маргаан. НЗД-ын 2020.02.05-ны А/149 дүгээр захирамжийг хүчингүй болгох "Шинэ центр" ХХК НЗД-ын 2017.06.20-ны өдрийн А/453 дугаар захирамжаар СБД-ийн 1-р хороонд байрлах 1 136 м.кв газрыг 15 жилийн хугацаагаар эзэмшин, 519,8 сая төгрөгийн хөрөнгө баригдсан гэдэг. Нийслэлийн өмчид бүртгэх ажил явагдаж байгаа. Нэхэмжлэлийг зөвшөөрөхгүй байгаа. 2020.07.22-ны өдрийн 71 дүгээр захирамжаар А/149 дүгээр захирамжийг түдгэлзүүлсэн. | Я.Одгэрэл | 2020.07.22-ны өдрийн 71 дүгээр захирамжаар А/149-ийг түдгэлзүүлсэн. |
| 4 | " Цэгц гэрэлт" ХХК | НӨАУГ | Захиргааны шүүх | Дамдинсүрэн | 2019.11.12 | СБД-ийн 1-р сургуулийн цайны газрын түрээсийн асуудлаар 2019.08.26-ны өдрийн сонгон шалгаруулалтад тэнцсэн тул гэрээ байгуулахыг даалгах, 2019.11.01-ний өдрийн сонгон шалгаруулалтыг хүчингүй болгуулах | Г.Уранцэцэг | Захиргааны хэргийн шүүхэд хянагдаж байна. |
| 5 | Иргэн н.Баасанжав /Хайрхан уул өргөө ХХК, ОСНАА-н дунд гол салбар | НӨАУГ | СБД-ийн иргэний шүүх | Уранчимэг 86441144 | 2014.04.24 | Дэнчин 24,6 сая төгрөг гаргуулах -2004 оны менежментийн гэрээний сонгон шалгаруулалтаар ялагч болсон. -2012 оны А/560-р захирамжаар гэрээг хаасан. | Ч.Мөнхбаяр | - 2018.09.25-ны өдрийн СБД-ийн шүүх 1951-р нэхэмжлэлийг хүчингүй болгосон - 2018.12.12 Нийслэлийн шүүхийн 2445-р магадлалаар 24,6 сая төгрөгийг иргэн Баасанжавт олгосон - 2019-05-02 УДШ 622 тогтоолоор шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон. |
| 6 | " ЖБГҮ" ХХК | НЗД, НӨАУГ | Захиргааны шүүх | Ганбат Туслах Баярдулам 91167722 | 2020.03.20 | СБД-ийн 10-р хороонд байрлах халуун усны барилгын хувьчлалын үнийн тухай - НӨХК-ын 2020.02.07-ны 9 дүгээр тогтоолыг хүчингүй болгох /2, 3, 4-г/ -86,3 сая төгрөгөөр худалдаж авах -504,5 сая төгрөгийг зөвшөөрөхгүй | Д.Рэнцэнбямба | Захиргааны хэргийн шүүхэд хянагдаж байна. |
| 7 | " Эс сайн" ХХК | НӨАУГ | Захиргааны шүүх | Уранчимэг, туслах Энхжаргал 88016595 | 2020.03.19 | Урт цагаан үйлчилгээний төвийн үйл ажиллагааг зогсоох тухай НЗД-ын А/216 дугаар захирамж, НИТХ-ын 11/65 тогтоолыг хүчингүй болгох | Д.Рэнцэнбямба | Анхан шатны шүүхэд хянаж байна. |
| 8 | " Хар дун" ХХК /Өргөө зочид буудал/ | НӨАУГ | Захиргааны шүүх | Оюунгэрэл, туслах Сайхантуяа 88991208 | 2019.03.06 | - НИТХ-ын 2018 оны 83 дугаар тогтоол /1,4 тэрбум төгрөгийг нийслэлийн өмчид бүртгэх/ - НИТХ-ын 2018 оны 20/21 дүгээр тогтоол /хувьчлах хөрөнгийн жагсаалт/ -НЗД-ын 2019 оны А/42 дугаар захирамжийг хүчингүй болгох /1 504 130 480 төгрөгийн хөрөнгө оруулалтын асуудал/ | М.Энхболд | 2020.04.30-ны өдрийн захиргааны шүүхийн 3322 тоот захирамжаар "Дун өргөө" ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг гадаадаас иртэл түдгэлзүүлсэн. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | " Алаг даага" ХХК | 2. НЗД<br>3. Төрийн Өмчийн бодлого зохицуулалтын газар<br>4. Ус сувгийн удирдах газар ОНӨАТҮГ | Захиргааны шүүх | Адъяасүрэн | 2020.02.11 | 1. НИТХ-ын 2007 оны 11/65 дугаар тогтоолын хэрэгжилтийг биелүүлэх /хувьчлах/<br>2. НЗД-ын 2020.02.19-ний өдрийн А/216 дугаар захирамжийг хүчингүй болгуулах<br>**3.** Ус, цахилгаанаар хангах<br>**4.** НИТХ-ын 2020 оны 73 дугаар тогтоол /1-р корпусыг бүртгэлээс хасах/ | Д.Рэнцэнхэмба | НЗД-ын 2020 оны А/216 дугаар захирамжийг түдгэлзүүлэн, НИТХ-ын 2020 оны 73 дугаар тогтоолыг хэвээр үлдээсэн. Анхан шатны шүүхэд хянагдаж байна. |
| 10 | Б.Ичинхорлоо | НЗД | ЧД-ийн шүүх | Энхтуяа, туслах Номин 90280169 | 2020.06.09 | Хүнс хангамжийн төвийг чөлөөлсөн Б/123 дугаар захирамжийг хүчингүй болгох, цалин олговор, нөхөж гаргуулах | М.Энхболд | Анхан шатны шүүхэд хянагдаж байна. |
| 11 | Иргэн Я.Эрдэнэчимэг туслах шүүгч н.Азбаяр 99970114 | НӨАУГ | Захиргааны шүүх | Ц.Одмаа | 2019.05.20 | Газрын маргаан, СБД-ийн 11-р хороонд газар давхардуулсан А/98 дугаар захирамжийг /НӨХГ-т/ хүчингүй болгох тухай | - | - 2020.02.18-ны өдрийн 387 дугаар тогтоолоор А/98 дугаар захирамжийг хүчингүй болгосон. - 2020.03.25-ны өдрийн 204-р магадлалыг дахин хэлэлцүүлэхээр буцаасан.<br>- 2020.07.01-ний өдрийн 269 дүгээр тогтоолоор магадлалыг хэвээр үлдээсэн. Захиргааны хэргийн анхан шатны шүүгч Мөнхтулга.<br>- 2020.09.11-ний өдөр нэхэмжлэгчийн нэмэлт бүрдүүлбэрээр захиргаанд гомдол гаргасан. Давж заалдах шатанд байгаа.<br>- 2020.04.30-ны өдрийн захиргааны шүүхийн 3322 тоот захирамжаар "Дун өргөө" ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг гадаадаас иртэл түдгэлзүүлсэн. |
| 12 | Зам тээврийн яам, Нийслэлийн Тээврийн газар, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар | 9 компани | ХУД, СБД, БГД, БЗД, СХД | | 2019.03....... | 9 компаниас 2009 онд улсаас нийлүүлсэн 400 ширхэг автобусны үнэ 31,7 тэрбум төгрөгийг нэхэмжлэх | М.Энхболд | 1. Автобус – 8ш – ХУД-ийн шүүх хэрэгсэхгүй болгосон.<br>2. "Зорчигч Тээвэр 3" ОНӨАТҮГ – 80 ш – СБД-ийн шүүх хэрэгсэхгүй болгосон.<br>3. "Эрдэм транс" ХХК – 30 ш – БГД-ийн шүүх 30 автобусыг НӨАУГ-т олгох<br>4. "Сутайн буянт" ХХК – 30 ш – СХД-ийн шүүх хэрэгсэхгүй болгосон.<br>Давах дахин шийдвэрлүүлэх<br>5. "Тэнүүн Огоо" ХХК – 50 ш – БГД-ийн шүүх 50 ш автобусыг НӨАУГ-т олгохоор шийдвэрлэсэн. |

2. Давж заалдах шатанд хянагдаж байгаа хэрэг

| Д/д | Нэхэмжлэгч | Хариуцагч | Шүүх | Шүүгч | Шүүхэд нэхэмжлэл гаргасан огноо | Нэхэмжлэлийн утга | Итгэмжлэгдсэн төлөөлөгч | Шийдвэр, тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Иргэн С.Гантогоо | НӨАУГ | БГД-ийн шүүх | Эрдэнэчимэг | 2020.09.28 | БГД-ийн 10-р хорооны Иргэний танхимийн байрны өмчлөл | Х.Батсайхан /итгэмжлэл гарч байгаа, Ганцоож байсан/ | 1. БГД 2020.09.28-ны өдрийн 2794-р тогтоолоо өмчлөх эрхийг шилжүүлсэн. 2. НӨАУГ нь 2020.10.28-ны өдрийн 04/1953 тоот албан бичгээр давж заалдсан |
| 2 | Иргэн Ц.Гаамаа | НӨАУГ | ЧД-ийн шүүх | Баярмаа | 2020.03.09 | Түрээсийн 3.4 сая төгрөгийг гаргуулах | Х.Батсайхан /итгэмжлэл гарч байгаа, Ганцоож байсан/ | 1. ЧДШ 2020.05.14-ний өдрийн 1099 дүгээр тогтоолоор НӨАУГ-аас 3,4 сая төгрөгийг гаргуулах 2. НӨАУГ давж заалдсан |

3. Хяналтын шатанд хянагдаж байгаа хэрэг

| Нэхэмжлэгч | Хариуцагч | Шүүх | Шүүгч | Шүүхэд нэхэмжлэл гаргасан огноо | Нэхэмжлэлийн утга | Итгэмжлэгдсэн төлөөлөгч | Шийдвэр, тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| " Анома" ХХК | НИТХ | ЧД-ийн шүүх | Алтанцэцэг | 2017.08.28 | 4,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт гаргуулах | Т.Оюунсувд | ЧД-ийн шүүх<br>1. 2018 оны 2/38 тоот шийдвэрээр 2 тэрбум төгрөг гаргуулахаар болсон.<br>2. 2018.12.21-ний өдөр Нийслэлийн шүүх 3,4 тэрбум төгрөг гаргуулахаар шийдвэрлэсэн.<br>3. УДШ 2019.05.14-ний өдөр 678-р шийдвэрээр анхан шатанд буцаасан.<br>4. ЧДШ 2020.05.26-ны өдрийн 1239-р шийдвэрээр 477,3 сая төгрөг гаргуулсан.<br>5. Нийслэлийн шүүх 2020.09.07-ны өдрийн 1900 дүгээр тогтоолоор 2,0 тэрбум төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн.<br>6. НИТХ-аас УДШ-д гомдол гаргасан. |
| " Гранд слаб" ХХК | НЗД | Чингэлтэй дүүргийн шүүх | Н.Даваасүрэн | 2020.03.... | БГД-ийн 3 дугаар хороонд 960 хүүхдийн сургууль, 280 хүүхдийн цэцэрлэгийг барьсан 18,4 тэрбум төгрөгийг гаргуулах | Х.Баттуяа | 1. ЧД-ийн шүүх – 2020.05.11-ний өдрийн 1052 дугаар шийдвэр, НЗДТГ-аас 18,4 тэрбум төгрөгийг гаргуулах<br>2. НШ – 2020.07.06-ны өдрийн 1506 магадлалаар хэвээр<br>3. УДШ-хяналтын гомдол гаргуулах |
| " Гангар инвест" ХХК | НИТХ, НЗД | Захиргааны шүүх | Н.Батзориг | - | НИТХ-ын 2018 оны 147 дугаар тогтоолыг хэрэгсэхгүй болгох | | - 2020.07.01-ний өдрийн 0454 дугаар шийдвэрээр НИТХ-ын 2018 оны 147 дугаар тогтоолыг хэрэгсэхгүй болгох<br>- 3,6 тэрбум төгрөгийг хэрэгсэхгүй болгох<br>- 2020.10.13-ны өдрийн 383 дугаар шийдвэрээр 147 дугаар тогтоолыг хэвээр үлдээх<br>- Нэхэмжлэгч гомдол гаргасан. |

## БУСАД АЖЛЫН ТАЛААР

### *5.1.Нийслэлийн төсөвт байгууллагууд, НӨҮГ-ууд болон бусад байгууллагуудад хийж хэрэгжүүлсэн ажил*

1. Нийслэлийн Засаг даргын баталж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хуулийн хэлтсийн дарга А.Даваажаргал, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Д.Эрдэнэжаргалаар ахлуулсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд,

Улаанбаатар хотын Захирагчийн харьяа газрууд, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын 2019 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тухай" ажлын хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 02 дугаар сарын 04-ний өдрүүдэд нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой 14 үйлдвэрийн газарт очиж ажилласан.

2. Нийслэлийн Засаг даргын үүрэг болгоны дагуу */"Үндэсний цэцэрлэгт хүрээлэн" ОНӨТҮГазрын урд талд наран шарлагын газар нэртэй 1 давхар үргэлжилсэн барилга болон тус газарт баригдаж буй саравч зэргийн зөвшөөрөл, мэдээллийг судалж, танилцуулах, ажлын хэсэг байгуулж ажиллах/* Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь тус газарт очиж хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалт, газар ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж, мэргэжлийн байгууллагаас 2018, 2019 онуудад хийсэн шалгалт, илэрсэн зөрчлийн талаарх мэдээллүүдийг нэгтгэн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан.
3. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулах "Үр дүнгийн гэрээ"-ний төслийг 2020 оны 03 дугаар сарын 25-ны байдлаар нийт ирүүлвэл зохих 17 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газраас 15 газар, 5 орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар ирүүлсэнийг судлан үзэж холбогдох санал өгч, гэрээний төсөлд тусгасан.
4. Нийслэлийн өмчит төсөвт үйлдвэрийн газар болон НӨААТҮГ-уудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлтийг өмчийн нэгдсэн мэдээллийн санд хийлгэж, хянан баталгаажуулж байна.
5. "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ, "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-уудын өр төлбөрийг барагдуулах асуудлыг НИТХ-ийн Тэргүүлэгчдийн 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэв. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гарсан Нийслэлийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/284 дүгээр захирамжийн дагуу үйлдвэрийн газруудын өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулав.
6. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны А/599 дүгээр тушаалаар байгуулагдсан "Төв цэнгэлдэх хүрээлэн" ХХК-д нягтлан шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр, 02 дугаар сарын 12-ны өдөр тус тус хуралдуулан, хурлаас гарсан шийдвэрийн дагуу холбогдох газрууд албан хүсэлт хүргүүлэн ажиллаж байна.
7. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын "Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын үйл ажиллагаатай танилцах" хуваарийг батлуулан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Уртнасан болон НЗДТГ-ын хэлтсийн дарга нарын бүрэлдэхүүн 2020.09.07-ний өдөр "Асгат" ОНӨААТҮГ-ын Төв аймгийн Баянчандмань суманд байгаа мал аж ахуй болон "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" ОНӨТҮГ-ын Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Бэлчээрийн менежмент төслийн нэгжийн үйл ажиллагаа, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалттай танилцлаа.
8. Татан буугдсан "Минж нутагшуулах, үржүүлэх төслийн нэгж" ОНӨТҮГ-ын санхүүгийн тайланд хийсэн Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн хяналт шалгалтын талаарх илтгэх хуудас, холбогдох маягт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас өр төлбөргүй тухай лавлагаа, мөнгөн тэмдэгтийн хураамж зэрэг бичиг баримтыг бүрдүүлэн Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 2/1645 тоот албан бичгээр Улсын бүртгэлийн ерөнхий газарт улсын бүртгэлээс хасуулах тухай хүсэлтийг хүргүүлсэн.

9. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 20,8 тэрбум төгрөгөөр батлуулан, худалдан авах хөрөнгө, бараа материалыг нэр төрлөөр нь багцлан "Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль", Засгийн газрын 2013 оны "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 68 дугаар тогтоолын баримтлан худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллах зөвшөөрлийг олгосон байна.
10. Нийслэлийн "Орон сууцны корпораци" хаалттай хувьцаат компанийн балансад бүртгэлтэй Баянзүрх дүүргийн 9-р хороо, 79 дүгээр сургуулийн багш ажилчдын 8 айлын орон сууц, мөн дүүргийн 23 дугаар хороо, 87-р сургуулийн багш ажилчдын 8 айлын орон сууцыг түрээслээд өмчлөх хэлбэрээр холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, олгох ажлыг зохион байгуулах тухай асуудлын танилцуулга тогтоолын төслийг бэлтгэн Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/626 тоотоор хуралд өргөн барьж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор албажуулан шийдвэрлүүлсэн. Тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон сууцнуудын үнэлгээг хийлгэхээр хөрөнгийн үнэлгээний компаниудад урилга илгээж, ирсэн саналуудыг судалсны үндсэн дээр "Үнэлгээ консалтинг" ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмжийг Нийслэлийн "Орон сууцны корпораци" хувьцаат компанид хүргүүлээд байна.
11. "Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2020 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 17 дугаар хуралд Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын балансад бүртгэлтэй, 1,725,696,000 төгрөгийн үнэ бүхий 30 айлын орон сууцыг "Нийслэлийн орон сууцны Корпораци" хувьцаат компани /хаалттай/-д балансаас балансад шилжүүлэх тухай асуудлыг танилцуулж хэлэлцүүлсэн.

## *ЗУРГААДУГААР БҮЛЭГ.*
## *1. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖЛУУД*

### *6.1.1.Иргэдийн өргөдөл, санал гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой мэдээлэл:*

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт 2020 онд 144 өргөдөл, гомдол албан хаагчид болон иргэд, ААН-ээс бичгээр ирүүлснийг хүлээн авч Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллалаа. Нийт 144 санал хүсэлт, өргөдөл гомдол ирсний 144 өргөдлийг шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлтийн дундаж хугацаа 12 хоног 4 цаг 10 минут, өргөдөл гомдлын индексийн үзүүлэлт "В" үнэлгээтэй байна. Шийдвэрлэх шатандаа судлагдаж байгаа хүсэлт, өргөдөл байхгүй, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 4 өргөдөл байна.

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга, орлогч дарга, хэлтсийн дарга нарт сар, улирал тутамд хугацаа хэтэрсэн, шийдвэрлэх хугацаа дөхсөн болон нийт өргөдлийн жагсаалт гарган танилцуулах хуудсаар танилцуулан албан хаагчдыг өргөдлийг хугацаандаа шийдвэрлэхийг мэдэгдсэн.

Өргөдөл гомдлыг шийдвэрлэх явцад нийт 136 зөрчил гаргасан байна. Үүнээс өдөрт нь багтааж хүлээж аваагүй 95, өдөрт нь багтааж шилжүүлээгүй 9, явцын тэмдэглэл хөтлөөгүй 32 зөрчлийг тус тус гаргасан байна.

***Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал:***

| Д/д | Хэлтэс | Шийдвэрлэлт | | | Шийдвэрлэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Шийдвэрлэгдсэн | Судлагдаж байгаа | Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн. | |
| **1** | Захиргаа санхүүгийн хэлтэс | 42 | - | - | 100% |
| **2** | Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтэс | 14 | - | 1 | 100% |
| **3** | Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс | 10 | - | 1 | 100% |
| **4** | Өмчийн мэдээлэл хяналт, ашиглалтын хэлтэс | 77 | - | 2 | 100% |
| | Нийт | 144 | - | 4 | 100% |

ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУГАЦААГ ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛБАЛ.




ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ХУГАЦАА

| № | | Өргөдлийн тоо | Хувь |
|---|---|---|---|
| 1 | 5 хоногт шийдвэрлэсэн | 51 | 35.66% |
| 2 | 10 хоногт шийдвэрлэсэн | 27 | 18.88% |
| 3 | 15 хоногт шийдвэрлэсэн | 16 | 11.19% |
| 4 | 30 хоногт шийдвэрлэсэн | 43 | 30.07% |
| 5 | Хугацаа сунгаж шийдвэрлэсэн | - | - |
| 6 | Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн | 4 | 2.80% |
| Нийт | | 144 | 100% |




*ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ХУГАЦААГ САР БҮРЭЭР ХАРЬЦУУЛБАЛ:*




***ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТИЙГ АГУУЛГААР НЬ АНГИЛБАЛ:***

- Архивын лавлагаа, мэдээлэл хүссэн тухай-17
- Түрээсийн төлбөртэй холбоотой- 57
- Урт цагаан төвийн үйл ажиллагаатай холбоотой -13
- Эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой-14
- Хүний нөөцтэй холбоотой */Ар гэрийн гачигдал, тэтгэвэр, тэтгэмж тусламж олгох, ажилд орох, ажлаас чөлөөлөгдөх, чөлөө хүсэх/* -15
- Дуудлага худалдааны дэнчин буцаах тухай-14
- Бусад - 14

***ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ХУГАЦААГ ХЭЛТЭС БҮРЭЭР ХАРУУЛБАЛ:***

- ЗСХ 41, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног 7 цаг 48 минут
- ӨБХХ 14, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 11 хоног 6 цаг 27 минут
- ӨТМХ 10, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 27 хоног 17 цаг 16 минут
- ӨМХАХ 77, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 13 хоног 23 цаг 33 минут

### *7.1.2. Ирсэн, явсан бичгийн бүртгэл, хяналтын ажлын талаар:*

Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын EDOC программд 2020 оны 01 дүгээр сарын 02-ноос 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн байдлаар нийт 4111 албан бичиг ирж бүртгэгдэж, хариу өгч хугацаанд нь шийдвэрлэсэн албан бичиг - 3776, судлагдаж байгаа албан бичиг 165, хугацаа хэтэрсэн шийдвэрлэсэн -170 албан бичиг байна. Албан бичгийн шийдвэрлэлт 95.94 хувьтай байна.

*АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ:*




| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Судалж байгаа | 24 | 11 | 38 | 84 | 8 | 0 | 165 |
| 2. | Хугацаа хэтэрсэн | 2 | 39 | 32 | 68 | 28 | 1 | 170 |
| 3. | Шийдвэрлэсэн | 13 | 569 | 1184 | 1367 | 614 | 29 | 3776 |

<u>*Албан бичгийн шийдвэрлэлтийг хэлтэс тус бүрээр хүснэгтээр харуулбал:*</u>

| Албан бичгийн шийдвэрлэлт | | Удирдлага | ЗСХ | ӨБХХ | ӨТМХ | ӨМХАХ | УЦУААТ | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ирсэн бичгийн тоо | | 39 | 619 | 1254 | 1519 | 650 | 30 | 4111 |
| Хариутай бичгийн тоо | | 11 | 137 | 156 | 220 | 92 | 6 | 622 |
| Шийдвэрлэлтийн | Хугацаандаа шийдвэрлэсэн | 6 | 115 | 136 | 195 | 71 | 5 | 528 |
| | Хугацаа хэтэрсэн | 0 | 18 | 7 | 11 | 17 | 1 | 54 |
| | Судалж байгаа | 5 | 4 | 13 | 14 | 4 | 0 | 40 |
| | Хугацаа сунгасан | 0 | 3 | 11 | 38 | 2 | 0 | 94 |
| | Хугацаа дөхсөн | 0 | 1 | 1 | 5 | 1 | 0 | 8 |
| | Хариутай бичгийн шийдвэрлэлтийн | 6 | 133 | 143 | 206 | 88 | 6 | 582 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо | | | | | | | | |
| Хаалтын байдал | Хугацаандаа хаасан | | 13 | 569 | 1184 | 1367 | 614 | 29 | 3776 |
| | Хугацаа хэтэрсэн | Хаасан | 2 | 21 | 25 | 57 | 11 | 0 | 116 |
| | | Хаагаагүй | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| | Судалж байгаа | | 19 | 7 | 25 | 70 | 4 | 0 | 125 |
| | Хариутай бичгийн хувь | | 88.89 | 97.79 | 98.84 | 97.68 | 99.01 | 100 | 97.35 |
| Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлийн хувь | | | 97.78 | 94.17 | 97.81 | 97.04 | 92.07 | 93.34 | 95.36 |
| Шийдвэрлэлтийн дундаж хугацаа /хоногоор/ | | | 5.72 | 6.78 | 9.9 | 15.48 | 9.86 | 9.83 | 9.6 |

Нийт албан хаагчдад 14 хоног тутам шийдвэрлэлтийн хугацаа дөхсөн болон хугацаа хэтэрсэн албан бичгийн мэдээг гарган, шийдвэрлэлтийн хугацаанд хяналт тавин ажиллаж байна.

*ЯВСАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ:*

Тайлант хугацаанд албан хаагчдын боловсруулсан, нийт 2059 албан бичгийн стандартад хяналт тавьж, бүртгэлийн дэвтэрт бүртгэн, дугаар өгч, EDOC программд оруулан, холбогдох байгууллагуудад илгээсэн.

Үүнээс 215 бичгийг албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу дугтуйлж, шуудангийн ажилтанд хүлээлгэн өгч, хүргүүлсэн байна.

*Явсан бичгийн бүртгэлийг хэлтэс тус бүрээр хүснэгтээр харуулбал:*

| Д/д | Хэлтэс нэгж | Нийт | Хариутай | Хариугүй |
|---|---|---|---|---|
| 1 | Захиргаа, санхүүгийн хэлтэс | 344 | 6 | 337 |
| 2 | Өмчийн бүртгэл хувьчлалын хэлтэс | 642 | 189 | 453 |
| 3 | Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс | 374 | 88 | 286 |
| 4 | Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс | 700 | 61 | 639 |
| | Нийт | 2059 | 344 | 1715 |

Албан бичгийн хэвлэмэл хуудас А4 -1698, А5-2038, тушаал-1452 ширхэгийг тус тус дугаарлан, албан хаагчдад олгохдоо дугаараар бүртгэн, хэвлэмэл хуудасны мэдээг гарган тухайн албан хаагчидтай тооцоо хийсэн. Нийт 34.280 төгрөгийн хэвлэмэл хуудсыг хүчингүй болсон байна.

### 6.1.3. Архивын ажлын талаар:

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын "Архивын баримтыг ирүүлэх тухай" 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дугаартай албан даалгавраар хуваарь гарган 2019.01.27-2019.02.21-ний хооронд албан хаагчдаас архивын хадгаламжийн нэгжүүдийг архивт хүлээн авсан.

***Графикаар харуулбал:***




- 70жил хадгалах-2 ХН
- Байнга хадгалах-250 ХН
- Түр хадгалах-273 Хн

2020 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар Байгууллагын архивт 2019 оны 523 хадгаламжийн нэгжүүдийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтаар ангилан төрөлжүүлэн бүртгэл хөтөлсөн.

2019 оны баримт бичгүүдийг хадгаламжийн нэгж болгосон. Үүнд:

1. Байгууллагаас явуулж байгаа нийт 1940 албан бичгийн хуудсыг дугаарлан, товъёог шивж, хадгаламжийн нэгжид тавих шаардлагыг хангаж нийт 12 хадгаламжийн нэгж болгон стандартын дагуу архивласан.
2. 2019 онд үүссэн байгууллагын архивтай холбоотой баримт бичгүүдийг стандартын дагуу архивлан хадгаламжийн нэгж болгон архивласан.

### *6.1.4.Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын тушаалын биелэлтийн талаар:*

Тайлант хугацаанд газрын даргын нийт 627 тушаал гарснаас "А" буюу хөрөнгө бүртгэн авах, балансаас балансад шилжүүлэх, данснаас дансанд шилжүүлэх, данснаас хасах зэрэг үндсэн чиг үүргийн дагуу 565 тушаал, "Б" буюу хүний нөөцийн чиглэлээр 62 тушаал гарч 100%-ийн биелэлттэй байна.

| № | Тушаалын нэр | Тоо | Биелэлт |
|---|---|---|---|
| А тушаал - 565 | | | |
| 1 | Эргэлтийн бус хөрөнгө бүртгэх тухай | 89 | 95% |
| 2 | Хөрөнгө данснаас хасах тухай | 281 | |
| 3 | Данснаас дансанд шилжүүлэх тухай | 48 | |
| 4 | Ажлын хэсэг байгуулах тухай | 47 | |
| 5 | Дуудлага худалдаа зохион байгуулах тухай | 4 | |
| 6 | Тээврийн хэрэгсэл данснаас хасах тухай | 46 | |
| 7 | Зардал гаргах тухай | 17 | |
| 8 | Бусад | 33 | |

| Б тушаал - 62 | | | |
|---|---|---|---|
| 9 | Ажилд томилох тухай | 18 | |
| 10 | Ажлаас чөлөөлөх тухай | 15 | |
| 11 | Сэлгэн ажиллуулах тухай | 6 | |
| | Шилжүүлэн ажиллуулах тухай | 5 | 100% |
| 12 | Тэтгэмж олгох тухай | 5 | |
| 13 | Чөлөө олгох тухай | 4 | |
| 14 | Бусад | 12 | |

### *6.1.5. Бусад ажлын талаар:*

Байгууллагын ажилтан, албан хаагчдын эерэг уур амьсгалыг сайжруулах, мэдлэгийн цар хүрээг тэлэх, олон нийтийн арга хэмжээн хамрагдах идэвхи оролцоог нэмэгдүүлэх, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх, хууль эрх зүйн мэдээллийг тогтмол хүргэх, цаг ашиглалтыг сайжруулах, албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн хэлтэс бүр тодорхой сэдвийн хүрээнд 14 хоног аяныг зохион байгуулсан байна. Аяны сэдэв:

- Захиргаа, санхүүгийн хэлтэс- Байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм журам, хууль эрх зүйн мэдээллийг албан хаагчдад өгөх аян /02.10-02.21/
- Өмчийн мэдээлэл, хяналт ашиглалтын хэлтэс- Дархлааг дэмжих аян /02.24-03.06/
- Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс- Хувцас жигдрэлтийн аян /03.09-03.20/
- Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтэс- Инээмсэглэл аян /03.23-04.03/
- Өмчийн мэдээлэл, хяналт ашиглалтын хэлтэс- Албан бичгийн стандарт, боловсруулалтыг сайжруулах /04.20-04.31/
- Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс- Стресс тайлах талаар мэдээлэл өгөх аян /05.04-05.15/
- Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтэс- Ажлын байрны эмх цэгцийг сайжруулах аян /05.18-05.29/


























- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын захирамжийн хүрээнд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 9, 10 дугаар хорооны сайжруулсан түлшний түгээлт борлуулалтад хяналт тавьж, мэдээ тайланг холбогдох газарт цаг хугацаанд нь хүргэж ажилласан. Мөн 2020.02.26-ны өдөр 8 албан хаагч нийслэлийн "Шуурхай штаб"-д 24 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, нийслэлийн 6 дүүргийн сайжруулсан түлшний түгээлт борлуулалтад хяналт тавьж ажилласан.
- Дэлхий нийтэд тархаад буй шинэ Короновирусын халдвараас урьдчилан сэргийлэх, иргэдийг сэрэмжлүүлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, улс, нийслэлийн Онцгой комиссын шийдвэр, Нийслэлийн Засаг даргын холбогдох захирамжууд, газрын даргын тушаалыг үндэслэн байгууллагын нийт 52 ажилтан, албан хаагч Нийслэлийн СБД-ийн 10,11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 02 дугаар сарын 21-ний өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл эргүүлийн үүргийг гүйцэтгэв.









- Газрын даргын 2020 оны "Гамшгаас хамгаалах орон тооны бус бүлэг штаб байгуулах тухай" А/61 дүгээр тушаалаар "гал унтраах, аврах", "хэв журам сахиулах", "эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх", "нөөц, хангалт хариуцах", "сургалт, сурталчилгаа хариуцах", "холбоо, зарлан мэдээлэл хариуцах" гэсэн 5 бүлэг байгуулан онцгой байдлын үед бэлэн байдлыг хангуулан ажиллаж байна.






Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд батлагдсан төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

- Газрын даргын А/76 дугаар "Хөрөнгө гаргах тухай" тушаалаар 5 961 850 төгрөгийн бараа материал татан авалт хийж, байгууллагын эмнэлгийн нөөц хангалтыг бүрдүүлсэн. /биеийн халуун хэмжигч -1, нэг удаагийн амны хаалт- 3600 ширхэг, хамгаалалтын хувцас хэрэглэл -10 ширхэг, гар ариутгагч 10 мянган литр, ариутгал халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээний бодис/
- 2020.02.14-ны өдрөөс байгуулагын хариуцлагатай жижүүрийн хуваарь батлуулан, албан хаагчид болон иргэдийг амны хаалттай эсэхэд хяналт тавих, биеийн халууныг хэмжих, ариун цэвэр болоод агаар сэлгэлтийг 2 цаг тутамд тогтмол хийлгэх, шаардлагатайгаас бусад тохиолдолд гадны иргэдийг дотогш

нэвтрүүлэхгүй уулзалтын бүртгэл хөтлөх үүрэг бүхий хариуцлагатай жижүүрийг томилон ажиллуулж байна.







“АМНЫ ХААЛТАА ЗҮҮЦГЭЭ” аяны хүрээнд албан хаагчдын дунд “Амны хаалтаа зүүцгээе” сэдэвт зурагт хуудас болон видео сурталчилгаа, шинэ санаа уралдаан зарлаж шалгарсан зурагт баннер, видео-1 олон нийтэд түгээж ажилласан.





Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Өгөөмөр нийслэлчүүд-2020” аянд байгууллагын албан хаагчид нэгдэж, идэвхитэй оролцов.

ХУД-ийн 4 дүгээр хорооны амжиргааны түвшин доогуур иргэдэд дэмжлэг үзүүлэх саналыг нийт албан хаагчид дэмжих хандав цуглуулан 2020.12.18-ны өдөр тус хорооны зохион байгуулагч 23 өрхийн хүнсний багц бүтээгдэхүүн, хүүхдийн гутал-7 г хүргэж өглөө.












Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын албан хаагчдын 81 хүүхдэд гарын бэлэг, уралдааны шагнал зэрэгт нийт 2.790,000 төгрөгийг санхүүжилт гарган ажиллалаа. Уралдааныг гар зураг, эссэ бичлэг, дуу /цахим/ гэсэн 3 төрлөөр шалгаруулж, шагнаж урамшуулсан болно.




"Ковид-19 бидний нүдээр" гар зургийн уралдаанд ирсэн бүтээлүүд.



"Хотын соёл" эссэ бичлэгийн уралдаан ирүүлсэн бүтээлүүд...



"Бяцхан дуучин" тэмцээний авъяаслаг бяцхан оролцогчид





2020.06.10-ны өдөр "Энэрэл эмнэлэг"-тэй хамтран биохимиийн шинжилгээ, цусны ерөнхий шинжилгээ, шээсний ерөнхий шинжилгээнд 61 албан хаагчдыг хамруулж, эрүүл мэндийн үзлэгт, зөвлөгөө мэдээллийг хүргүүлж ажиллалаа.





Нийслэл Улаанбаатар хот байгуулагдсаны 381 жилийн ой, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойг угтан 2020 оны 10 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын төв байр болон Засаг захиргааны 4 дүгээр байрны 2 давхарт "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг зохион байгуулан иргэн, ААН-д үзүүлж буй төрийн үйлчилгээг шуурхай хүргэх зорилгоор үйл ажиллагаагаа сурталчлан, тэдэнд мэдээлэл өгөх хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган газрын даргаар батлуулан ажилласан.





- Байгууллагын бүтэц танилцуулга,
- Хэлтэс тус бүрийн үйл ажиллагаа, чиг үүрэг
  - *Захиргаа, санхүүгийн хэлтэс;
  - *Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтэс;
  - *Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс;
  - *Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс;










Байгууллагаар үйлчлүүлэхэд бүрдүүлэх материал: /брошур хэлбэрээр/













Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн “Дэлхийн алхалтын өдрийг иргэдэд сурталчлах, идэвхтэй хөдөлгөөнөөр тогтмол хичээллэх, биеийн дархлааг дэмжих, өдөр тутамдаа алхаж авто машины түгжрэлийг бууруулах, эрүүл чийрэг Монгол хүнийг бий болгох” гэсэн удирдамжийн дагуу Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар Захиргаа, санхүүгийн хэлтэс “Явган аялал”-ын удирдамжийг боловсруулан 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдөр нийт 45 албан хаагч Сонгино хайрхан ууланд 3,5 км явган аялалыг зохион байгуулан ажиллалаа.





***Цаашид авах арга хэмжээ:***

- Нийслэлийн өмчийн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам", "Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай Контракт байгуулах, дүгнэх журам", "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам", "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам", "Нийслэлийн өмчийн байр, талбайг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам", "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам", "Нийслэлийн өмчийг хувьчлах журам", "Нийслэлийн өмч хувьчлах комиссын ажиллах журам", "Нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжин ирж буй нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэх журам" зэрэг байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг журмуудыг шинэчлэн боловсруулах, батлуулах;
- Нийслэлийн өмчит төсөвт 756 байгууллагатай "Өмч эзэмшүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулах;
- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого зохион байгуулах тухай" 9 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компаны засаглалыг сайжруулах, бүтцийн өөрчлөлт хийх, үйлдвэрийн газрыг үр ашигтай ажиллуулах нэмэлт хөрөнгө оруулалт татах, үнэт цаас бонд гаргах арга замыг судлах, өмчийн талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх;
- Нийслэлийн өмчит байгууллага, аж ахуй нэгжүүд, үйлдвэрийн газруудын эзэмшиж ашиглаж буй газрыг хамгаалах, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх;
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, нийслэлийн ОНХС, замын сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнд шинээр бий болсон барилга, тээврийн хэрэгслүүдийг нийслэлийн өмчийн бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулан гүйцэтгэх;
- Нийслэлийн өмчөөс хувьчлагдах эд хөрөнгийн жагсаалтад орж батлагдсан болович хувьчлагдаагүй, барилга байгууламжууд дээр хэрэгжүүлэх төсөл, хөрөнгө оруулалтын талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн өмчит болон нийлэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдтэй хамтран судалж, санал боловсруулах;
- Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойн төлөвлөгөөт арга хэмжээг зохион байгуулах;

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН: М.БАЯРАА /НӨАУГ-ЫН ДАРГА/
Д.ТӨМӨРБААТАР /НӨАУГ-ЫН ОРЛОГЧ ДАРГА/
Д.РЭНЦЭНБЯМБА /НӨАУГ-ЫН ОРЛОГЧ ДАРГА/

ХЯНАСАН: А.МӨНГӨН /ЗСХ-ИЙН ДАРГА/

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: Б.УУГАНЦЭЦЭГ /ЗСХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН/

D:\2020 on\tailan\tailan\НӨАУГ 2020 оны I улирал.docx